

БАТЛАВ.**БАТЛАВ.****БАТЛАВ.****АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС
БАЯЛГИЙН САЙД****САНГИЙН САЙД****ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

.....

.....

.....

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэж заасан. Үндсэн хуулийн энэхүү нэмэлт, өөрчлөлтийн суурь үзэл санааг амилуулах, газрын тос, уламжлалт бус газрын тосны салбарын гэрээний төрлүүдийг ашиглах боломжийг бий болгох, одоо хүчин төгөлдөр мөрдөж буй гэрээг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх замаар Монгол Улсад орох баялгийн бодит өгөөжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Бусад хууль, тухайлбал Үндэсний баялгийн сангийн болон Зөвшөөрлийн тухай хуультай салбарын хуулийг уялдуулах шаардлага бий. Тухайлбал, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10, 11, 12 дугаар зүйлд заасан ирээдүйн өв сан, хуримтлалын сан, хөгжлийн сангуудын орлого бүрдүүлэлтийн суурь зарчимд нийцүүлэх шаардлагатай байна.

Мөн Зөвшөөрлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйл, 5.1, 5.2, 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шуурхай болгох, хүнд суртал, авлигаас сэргийлэх суурь зарчимд нийцүүлэх, газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулиар тогтоосон жагсаалт, бүрэн эрхийн хүрээнд олгох, сунгах, түдгэлзүүлэх харилцааг зохицуулах, зөвшөөрлийн шат дамжлагыг цөөлөх, мөн сонгон шалгаруулалтыг цахимжуулах замаар хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд төрөөс учруулах захиргааны дарамтыг багасгаж, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн баталгааг хангах шаардлагатай байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.4.3-т “Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг багасгаж, улмаар ... дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ бүрэн хангана. Үнийн хэт хэлбэлзэлд өртөх эрсдэлээс сэргийлж, улсын нөөцийг түүхий нефтээр 6 сараас доошгүй хэмжээнд байлгана” гэж стратегийн зорилтыг тодорхойлсон. Энэхүү үндэслэлийн хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний хувьд нэг улсаас

хамааралтай байдлыг үе шаттайгаар бууруулж, Газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдээр тасралтгүй, найдвартай хангах нөхцөлийг болон мөн улсын стратегийн нөөцийг түүхий тосоор 6 сараас доошгүй хугацаагаар бүрдүүлэх эрх зүйн баталгааг бий болгож, хөрөнгө оруулалтын таатай орчныг салбарын хуулиар шинэчлэн тогтоох эрх зүйн шаардлага үүсэж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4.2.16-д “Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулна.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 3.3-т “Газрын тосны баталгаат нөөцийг өсгөж, олборлолтыг нэмэгдүүлэх замаар дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангана.” гэж, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн Зорилт 3.3-т “Газрын тосны баталгаат нөөцийг өсгөж, олборлолтыг нэмэгдүүлэх замаар дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангана.”, “3.3.1. Газрын тосны бүтээгдэхүүний импортын хараат байдлыг бууруулж, дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулан нефть-химийн аж үйлдвэрийн суурийг тавих”, “3.3.2. Газрын тосны ашиглалтын баталгаат нөөцийг өсгөж, газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдээр хангах дамжуулах хоолойг барьж байгуулах” гэж, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтын 3-т “11. Газрын тос боловсруулах төслүүд /Газрын тосны нөөц хайгуулын төсөл, газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой, дагалдах барилга байгууламжийн төсөл/”, эдгээрт холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн 12-т “Газрын тос боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 1.5 сая тонн түүхий тосноос 1.3 сая тонн бүтээгдэхүүн гарган авч, дотоодын газрын тосны хэрэглээний 50 орчим хувийг хангах, импортын хараат байдлыг бууруулах, шатахууны үнийг бие даан, уян хатан зохицуулах боломж бүрдэнэ.” гэж, 3.3.1.6-д “Дорноговь аймагт дотоодын түүхий эдэд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, олон улсын стандартын шаардлага хангасан авто бензин, түлшний тодорхой хувийг дотоодоосоо хангах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж тус тус заасан нь хуулийн төсөл боловсруулах үндэслэл болж байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын 3.6.2-т “Дорноговь аймгийн Алтанширээ суманд газрын тосны бүтээгдэхүүн, химийн үйлдвэрийг бусад дагалдах үйлдвэрийн хамт байгуулна.” гэж тусгажээ.

Мөн Газрын тосны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ болон хуулийн давхардал, зөрчил, хийдлийн судалгаагаар Газрын тосны тухай хуулийг холбогдох бусад хуультай харьцуулан шинжлэхэд нийт 80

гаруй давхардал, зөрчил, хийдэл байгааг тогтоосон тул эдгээрийг арилгаж, хууль хоорондын уялдаа, нийцлийг хангах шаардлага үүссэн.

Иймд газрын тосны салбарын эрх зүйн орчныг Монгол Улсын Үндсэн хууль, хөгжлийн бодлого, олон улсын чиг хандлагад нийцүүлэн цогцоор нь шинэчлэх хууль зүйн шаардлага үүсэж байна.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарт нийцсэн болно.

1.2.Практик шаардлага

Хүчин төгөлдөр үйлчилж буй Газрын тосны тухай хууль (2014) нь тус салбарын хөгжлийн өнөөгийн шаардлагад нийцэхгүй болжээ. Энэ нь нэг талаар холбогдох бусад хууль тогтоомжтой уялдаа, нийцэлгүй болсонтой холбоотойгоос гадна нөгөө талаар хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааг Бүтээгдэхүүн хуваах гэрээнээс бусад төрлийн гэрээгээр зохицуулах боломжийг бий болгох, өртөг нөхөх зардлын хяналтын шат дамжлагыг багасгах, түүнчлэн нүүрсний давхаргын метан хий зэрэг уламжлалт бус газрын тосны эрх зүйн зохицуулалтыг бие даасан байдлаар боловсронгуй болгох зэрэг практик шаардлага, шалгуурыг хангахгүй байгаатай холбоотой байна.

Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны үр дүнд дараах үндсэн шалтгаан, нөхцөл тогтоогдлоо. Тухайлбал:

1. Монгол Улсын газрын тосны олборлолт 2015 онд оргилдоо буюу 1.2 сая тоннд хүрч байсан бол өнгөрсөн хугацаанд хөрөнгө оруулалт буурсны улмаас 2025 онд 513 мянган тонн болж даруй 2 дахин буурсан. 2028 онд ашиглалтад орох Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр тасралтгүй хангахын тулд хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлж, шинээр нөөц бэлтгэх, олборлолтыг нэмэгдүүлэх практик шаардлага тулгарч байна.

2. Газрын тосны салбарын эрх зүйн зохицуулалт бусад хууль тогтоомжтой нийцэл хангалтгүй болсон нь хэрэгжилтийн хүндрэл үүсгэж байна. Газрын тосны тухай хууль батлагдсанаас хойш Захиргааны ерөнхий хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Татварын багц хууль, Байгаль орчны холбогдох хууль тогтоомж болон бусад олон хууль шинэчлэгдсэн боловч Газрын тосны тухай хуулийн зохицуулалт эдгээртэй бүрэн нийцээгүй хэвээр байна. Үүний улмаас эрх зүйн давхардал, хийдэл, ойлгомжгүй зохицуулалт үүсэж, хууль хэрэгжүүлэх байгууллага болон хөрөнгө оруулагчдын хувьд эрх зүйн тодорхой бус байдал бий болсоор байна.

3. Монгол Улс өнөөдрийг хүртэл газрын тосны үйл ажиллагааг үндсэндээ бүтээгдэхүүн хуваах гэрээний нэг хэлбэрээр зохицуулж байгаа нь хөрөнгө оруулагчийн сонголтыг хязгаарлаж, төслийн эдийн засгийн онцлогт тохирсон гэрээний хэлбэр сонгох боломжийг бүрдүүлэхгүй байна. Харин дэлхийн газрын тосны томоохон үйлдвэрлэгч улс орнууд бүтээгдэхүүн хуваах гэрээ, татвар-роялтийн тогтолцоо, орлого хуваах гэрээ, хамтарсан хөрөнгө оруулалтын гэрээ зэрэг бусад төрлийн гэрээг хэрэглэж, хөрөнгө оруулалтын өрсөлдөх чадвараа нэмэгдүүлж байна. Иймээс Монгол Улсын хүчин төгөлдөр хууль нь хөрөнгө оруулалтын орчны хувьд өрсөлдөх чадвар алдагдах эрсдэлийг бий болгож байна.

4. Татварын хууль тогтоомжид орсон өөрчлөлтөөс шалтгаалан өмнө нь бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан хөрөнгө оруулагчдын эрх зүйн баталгаа

суларч, хөрөнгө оруулалт буурч, хайгуул, судалгааны ажил зогсонги байдалд ороход нөлөөлсөн.

5. Монгол Улсад уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын үйл ажиллагаа хэрэгжиж байгаа боловч уг үйл ажиллагааны онцлогийг тусгасан хууль эрх зүйн зохицуулалт хангалтгүйгээс хөрөнгө оруулалт татах боломж хязгаарлагдаж байна. Нүүрсний давхаргын метан хий, шатдаг занар зэрэг уламжлалт бус газрын тос нь уламжлалт газрын тосноос технологи, хайгуулын хугацаа, олборлолтын горимоор ялгаатай боловч хүчин төгөлдөр хуульд ижил журмаар зохицуулж байгаа нь хөрөнгө оруулалтын эрсдэлийг нэмэгдүүлж, олон улсын хөрөнгө оруулагчдын оролцоог бууруулж байна.

6. Өртөг нөхөх зардлын хяналт, шалгалт, баталгаажуулалтын шат дамжлага олон, нэг ижил санхүүгийн баримтыг хэд хэдэн байгууллага давхар хянаж байгаа нь аудитын хугацааг уртасгаж, өртөг нөхөх зардлын тооцоог хугацаанд нь баталгаажуулах боломжийг хязгаарлаж байна. Үүний улмаас бүтээгдэхүүн хуваах тооцоо саатаж, хөрөнгө оруулагчийн мөнгөн урсгал, улсын төсөвт төвлөрөх орлогын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ төр, хөрөнгө оруулагчдын хооронд үүсэх захиргааны болон шүүхийн маргаан нэмэгдэх нөхцөл бүрдэж байна.

7. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн дагаж мөрдөх хугацаа нь газрын тос боловсруулах үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлснээр дуусгавар болох зохицуулалттай тул тус хуульд тусгасан газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусган, эрх зүйн зохицуулалтын залгамж чанар, тогтвортой байдлыг хангах шаардлагатай байна.

8. Хууль тогтоомж болон Бүтээгдэхүүн хуваах гэрээнд орон нутгийн хөгжлийн дэмжлэгийг сайн дурын байдлаар зохицуулсан нь эрх зүйн тодорхой бус байдал үүсгэж, талуудын ойлголтын зөрүүг бий болгож байна. Үүний улмаас орон нутгийн эсэргүүцлээс шалтгаалан төслийн ажил саатах тохиолдол гардаг боловч хугацааг царцаах, сунгах зэрэг эрх зүйн механизм тодорхойгүй байна. Мөн ийм саатлыг давагдашгүй хүчин зүйлд тооцох эрх зүйн үндэслэл тодорхой бус байгаа нь хөрөнгө оруулагчдын эрх зүйн баталгааг сулруулж байна.

9. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Газрын тосны тухай хуулийн зарим нэр, томъёо, түүний агуулга нь Газрын тос, байгалийн хийн баялгийн менежментийн систем (PRMS)-тэй нийцэхгүй байна.

Эдгээрийг арилгах зорилгоор дараах шинэчлэлүүдийг хуулийн төсөлд тусгах шаардлагатай. Үүнд:

1. *Хуулийн уялдаа нийцэл:* Газрын тосны тухай хуулийг холбогдох бусад хуультай харьцуулан давхардал, зөрчил, хийдлийг арилгаж, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах;

2. *Гэрээний тогтолцоо:* Зөвхөн Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хязгаарлахгүйгээр Татвар-нөөц ашигласны төлбөрийн гэрээ, Орлого хуваах гэрээ, Хамтарсан хөрөнгө оруулалтын гэрээний төрлөөс сонгох боломжийг бий болгох, одоогийн гэрээлэгчдэд шинэ гэрээний төрлүүд рүү сайн дураар шилжих эрх зүйн боломжийг олгох (18, 19 дүгээр зүйл), газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын гэрээ байгуулах, гэрээний төрөл өөрчлөх, гэрээ цуцлах, эрх үүрэг шилжүүлэх зэрэг бодлогын эцсийн шийдвэр гаргах эрх

хэмжээг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хариуцуулж, шийдвэр гаргалтыг шуурхай болгох (9, 19, 20, 21, 22 дугаар зүйл);

3. *Татварын орчин*: Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс гэрээ байгуулах үед мөрдөгдөж байсан татварын орчинг тогтворжуулах (45 дугаар зүйл);

4. *Уламжлалт бус газрын тосны зохицуулалт*: Уламжлалт бус газрын тосны харилцааг бие даасан бүлгээр нарийвчлан зохицуулах (5 дугаар бүлэг);

5. *Зардлын баталгаажуулалт*: Өртөг нөхөх зардлын баталгаажуулалтыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хянаж, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаажуулахаар шат дамжлагыг багасгах (42 дугаар зүйл);

6. *Газрын тосны төрийн өмчит компани*: Газрын тосны төрийн өмчит компанитай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг бий болгох (12 дугаар зүйл);

7. *Орон нутгийн харилцаа*: Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөрийг тухайн гэрээт талбай орших сум, дүүргийн төсөвт 45 хоногийн дотор шууд төвлөрүүлэх. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагаа эхлэхээс өмнө сум, дүүргийн Засаг дарга болон газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдийн нийгмийн хамгаалалд дэмжлэг үзүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх талаар харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тусгасан Хамтын ажиллагааны гурвалсан гэрээг байгуулах зохицуулалтыг тусгах (43, 47 дугаар зүйл);

8. *Хариуцлага, ил тод байдал*: Төрийн байгууллага, албан тушаалтны хуульд заасан үүргийг хугацаанд нь хэрэгжүүлэх, хууль зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэх, хууль бус шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүйн улмаас учирсан хохирлыг нөхөн барагдуулах, түүнчлэн төрийн байгууллага болон гуравдагч этгээдийн хууль бус үйл ажиллагааны улмаас газрын тостой холбогдсон үйл ажиллагаа саатсан тохиолдолд гэрээ, тусгай зөвшөөрөл болон холбогдох үүргийн хэрэгжилтийн хугацааг зохих журмын дагуу сунгах, хойшлуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох (50, 51 дүгээр зүйл);

9. *Хөрөнгө оруулалтыг дэмжих*: Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаатай холбогдуулан гэрээлэгчээс хуульд заасан нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөр, сургалтын урамшууллаас бусад аливаа төлбөр, хураамж, хандив, тусламж, эсхүл нэр төрөл үл харгалзан төрийн болон орон нутгийн байгууллагын нэрээр төлбөр, хураамж авахыг хориглох (46 дугаар зүйл), хайгуулын үе шатанд татан буулгалтын барьцаа хөрөнгийг байршуулах үүргээс гэрээлэгчийг чөлөөлөх (14 дүгээр зүйл), бүтээгдэхүүн хуваах гэрээний хувьд өртөгт тосны хэмжээг гэрээгээр харилцан тогтоох (18 дугаар зүйл);

10. *Хуулийн нэр томъёоны тодорхойлолт*: Монгол Улсад Газрын тос, байгалийн хийн баялгийн менежментийн систем (PRMS)-ийг дагаж мөрдөх болсонтой холбогдуулан Газрын тосны тухай хуулийн зарим нэр томъёог өөрчлөх, шинээр нэмэх (4 дүгээр зүйл);

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалт, олборлолт, тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах, хөрөнгө оруулалтын таатай эрх зүйн орчныг бүрдүүлэх, хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх, нөөцийг нэмэгдүүлэх, дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр тогтвортой, найдвартай хангах, Үндэсний баялгийн санг арвижуулах, улсын эрчим хүчний аюулгүй байдал, бие даасан байдлыг бэхжүүлэхэд оршино.

Газрын тосны тухай хуульд зарчмын шинжтэй шинэ зохицуулалтуудыг оруулахаас гадна нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орохоор байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т заасны дагуу хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь бүтцийн хувьд:

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл (1-6 дугаар зүйл) - Хуулийн зорилго, хууль тогтоомж, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, газрын тос, уламжлалт бус тосны баялаг нь төрийн нийтийн өмч байх болон салбарт баримтлах суурь зарчим;

Хоёрдугаар бүлэг. Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын бүрэн эрх (7-12 дугаар зүйл) - УИХ, Засгийн газар, салбарын Яам, Агентлаг, бүх шатны ИТХ ба Засаг даргын бүрэн эрх, мөн Газрын тосны төрийн өмчит компанийн арилжааны бие даасан бүрэн эрх;

Гуравдугаар бүлэг. Гэрээлэгч, оператор компани, туслан гүйцэтгэгчийн эрх, үүрэг (13-17 дугаар зүйл) - Гэрээлэгчийн эрх, нийтлэг үүрэг, хүний нөөц, нийгмийн хариуцлагын үүрэг, дотоодын ханган нийлүүлэлтийг дэмжих, оператор ба туслан гүйцэтгэгчийн хүлээх үүрэг;

Дөрөвдүгээр бүлэг. Гэрээний төрөл, гэрээг өөрчлөх, цуцлах нөхцөл (18-22 дугаар зүйл) - Гэрээний төрөл (БХГ, Татвар-нөөц ашигласны, Орлого хуваах, Хамтарсан хөрөнгө оруулалт), гэрээний төрлийг өөрчлөх, гэрээ цуцлах үндэслэл, эрх үүрэг шилжүүлэх болон гэрээний биелэлтийг дүгнэх;

Тавдугаар бүлэг. Уламжлалт бус газрын тос (23-28 дугаар зүйл) - Уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд тавигдах тусгай шаардлага, татвар, санхүү, гэрээний урамшуулал, эрэл, хайгуул, үнэлгээний хөтөлбөр, нүүрсний давхаргын метан хийн олборлолт, талбайн хэмжээ, ашиглалтын хугацаа, бусад ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбайн давхцалыг зохицуулах;

Зургаадугаар бүлэг. Хайгуул, ашиглалт, тусгай зөвшөөрөл (29-35 дугаар зүйл) - Нээлттэй сонгон шалгаруулалт, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох, сунгах, нээлт, үнэлгээ, олборлолтын туршилт, туршилтын олборлолт, баялаг нөөцийг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, сунгах, ашиглалтын үйл ажиллагаа болон үйл ажиллагаа саатсан тохиолдолд хугацааг царцааж хойшлуулах;

Долоодугаар бүлэг. Тээвэрлэлт, хадгалалт, талбайн хэсэгчилсэн буцаалт (36-38 дугаар зүйл) - Талбайг хэсэгчлэн буцаах, хадгалах сав байгууламж болон хураагуурын орон зай ашиглах, автомашин, төмөр зам болон дамжуулах хоолойгоор тээвэрлэх;

Наймдугаар бүлэг. Хяналт, бүртгэл, хэмжилт (39-40 дүгээр зүйл) - Анхдагч ба үр дүнгийн тайлан, геологийн цахим дата хүлээлцэх, дээж хилээр нэвтрүүлэх, хэмжилтийн болон хүргэлтийн цэгийг ажиллуулах, хөндлөнгийн хэмжилт, шугам хоолойн технологийн алдагдлын дээд хязгаар;

Есдүгээр бүлэг. Өртөг нөхөх зардлын хяналт, шалгалт, баталгаажуулалт, төлбөр хураамж (41-46 дугаар зүйл) - Мэдээ тайлан гаргах, өртөг нөхөх зардлыг баталгаажуулах, тусгай зөвшөөрлийн төлбөрийг орон нутагт хуваарилах, нөөц ашигласны төлбөр ногдуулах (уламжлалт 5-12%, уламжлалт бус 5-8%), Татварын тогтвортой байдал, хууль бус төлбөр шаардахыг хориглох;

Аравдугаар бүлэг. Орон нутгийн харилцаа, иргэдийн оролцоо (47 дугаар зүйл) - Хамтын ажиллагааны гурвалсан гэрээ байгуулах, орон нутагт олгох дэмжлэгийн хэмжээ, зориулалтын бусаар зарцуулахыг хориглох;

Арваннэгдүгээр бүлэг. Гомдол гаргах, маргаан шийдвэрлэх (48-49 дүгээр зүйл) - Гэрээний маргааныг Монгол Улсын шүүх эсхүл олон улсын арбитраар шийдвэрлэх, Захиргааны актад гомдол гаргах;

Арванхоёрдугаар бүлэг. Хариуцлага (50, 51 дүгээр зүйл) - Төрийн байгууллага, албан тушаалтны хүлээх хариуцлага (30 өдрийн хугацаа хэтрүүлбэл Төрийн албаны хуулиар шийтгэх), хууль зөрчигчдөд Иргэний хууль Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх, хохирол барагдуулах;

Арвангуравдугаар бүлэг. Бусад зүйл (52, 53 дугаар зүйл) - Дагаж мөрдөх журмуудыг батлах, хууль хүчин төгөлдөр болох хугацаа.

Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь салбарын харилцааг бүрэн, цогц зохицуулах зорилгоор 13 бүлэг, 53 зүйлээс бүрдсэн ерөнхий бүтэцтэй байна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

3.1. Нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн

1. *Эдийн засгийн үр дагавар, хүрэх үр дүн:* Олон улсын жишигт нийцсэн гэрээний бусад төрлийг хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд хэрэглэж, татварын орчин тогтворжсоноор хөрөнгө оруулалт нэмэгдэх, хайгуул, судалгааны ажил эрчимжих, нөөц өсөх, олборлолт нэмэгдэх, газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдээр тасралтгүй, найдвартай хангах нөхцөл бүрдэнэ.

2. *Нийгмийн үр дагавар, хүрэх үр дүн:* Нүүрсний давхаргын метан хийн эдийн засгийн үр ашигтай нөөцийг илрүүлж, арилжааны эргэлтэд оруулах замаар эрчим хүчний хараат байдлаас гарч, хот суурин газрын агаар, орчны

бохирдлыг бууруулахад бодит ахиц гарна. Тусгай зөвшөөрлийн төлбөрийг 100% сум, дүүргийн төсөвт 45 хоногийн дотор төвлөрүүлж, "Хамтын ажиллагааны гурвалсан гэрээ"-г заавал байгуулдаг болсноор орон нутагт ажлын байр шинээр бий болох, иргэдийн нийгмийн хамгаалалд дэмжлэг үзүүлэх, иргэдийн амьжиргаа дээшлэх нөхцөл бүрдэнэ.

3. *Хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн:* Салбарын хууль тогтоомжийн 80 гаруй давхардал, хийдэл, зөрчил арилж, олон улсын Газрын тос, байгалийн хийн баялгийн менежментийн систем (PRMS) болон Үндсэн хууль, холбогдох бусад хуультай нийцсэн эрх зүйн нэгдмэл орчин бүрдэнэ, зардлын баталгаажуулалтын шат дамжлага багасна. Албан тушаалтан ажлын 30 өдөрт шийдвэр гаргах үүрэгтэй болж, хугацаа хэтрүүлбэл Төрийн албаны хуулиар хариуцлага хүлээх механизм сууснаар хууль дээдлэх зарчим, хөрөнгө оруулалтын орчин сайжирна.

3.2. Сөрөг үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл хэрэгжих явцад зарим сөрөг үр дагавар, хүндрэлүүд үүсэж болзошгүй бөгөөд тэдгээрийг дараах арга хэмжээний хүрээнд шийдвэрлэнэ. Тухайлбал:

1. Хайгуул, олборлолтын ажил эрчимжих хэрээр бэлчээр, байгаль орчинд нөлөөлөхөөс эмээсэн иргэдийн эсэргүүцэл үүсэж болзошгүй. Үүнийг шийдвэрлэхийн тулд "Хамтын ажиллагааны гурвалсан гэрээ"-гээр орон нутагт олгох дэмжлэгийг хууль, эсхүл гэрээнд заасан хувиар сум, дүүргийн төсөвт шилжүүлнэ. Засаг дарга хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглож, тайлагнадаг харилцан хяналтын механизмтай болгоно.

2. Гэрээлэгч хайгуулын үе шатанд татан буулгалтын барьцаа хөрөнгийг байршуулах үүргээс чөлөөлөгдөж, татан буулгалтын барьцаанд зарцуулагдах хөрөнгийг хайгуул, судалгааны ажилд зарцуулах боломж бүрдэнэ. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь татан буулгалтын зардлын баталгаа болгон гэрээлэгчид ногдох ашигт тосны 1 хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр арилжааны банкны хадгаламжийн дансанд урьдчилан байршуулж, татан буулгалтын ажилд гурвалсан хяналтын дор зарцуулна.

3. Газрын тосны төрийн өмчит компанид талбайг давуу эрхээр олгох нь стратегийн салбарт үндэсний аюулгүй байдлыг хангах зорилготой бөгөөд уг компани нь Компанийн тухай хуулийн дагуу арилжааны бие даасан зарчмаар ажиллана. Газрын тосны төрийн өмчит компанийг зөвхөн хувийн хэвшилтэй хамтрахаар хатуу тулгахгүй бөгөөд бие даан болон бусад эх үүсвэрээр ажиллах нээлттэй боломжийг олгож эрсдэлийг хаана.

Дөрөв. Хуулийн төсөл нь бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал;

4.1. Хуулийн төсөл бусад хуультай уялдсан байдал

Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчим, үзэл баримтлалд бүрэн нийцсэн бөгөөд салбарын болон суурь хууль тогтоомжуудтай дараах байдлаар уялдана. Үүнд:

1. Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасан стратегийн ач холбогдол бүхий байгалийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх зарчимд нийцүүлнэ.

2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны үйл ажиллагаанаас төрд ногдох ашигт тос, нөөц ашигласны төлбөр, гэрээний урамшууллын орлогыг Үндэсний баялгийн сангийн Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сангуудад уялдуулан төвлөрүүлнэ.

3. Зөвшөөрлийн тухай хуультай уялдуулан тусгай зөвшөөрлийг цахимаар олгох, сунгах, шат дамжлагыг цөөлөх, хөрөнгө оруулалтыг дэмжих зарчмыг баримтална.

4. Төсвийн тухай хуультай уялдуулан тусгай зөвшөөрлийн төлбөрийг тухайн гэрээт талбай орших сум, дүүргийн төсөвт шууд хуваарилах зохицуулалтыг хангана.

4.2. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаарх санал

Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Ашигт малтмалын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай, Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Зөвшөөрлийн тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Татварын ерөнхий хууль, Төсвийн тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай, Зөрчлийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Төрийн аудитын тухай, Үндэсний баялгийн сангийн тухай, Усны тухай, Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай, Эрчим хүчний тухай, Барилгын тухай, Хөрөнгө оруулалтын тухай, Эрүүгийн хууль зэрэг хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Мөн Шинэчилсэн найруулга батлагдахаас өмнө байгуулагдсан, хүчин төгөлдөр үйлчилж буй Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд болон тусгай зөвшөөрлүүдийн хууль ёсны хүчин төгөлдөр байдлыг хадгалах, шинээр нэвтрүүлж буй гэрээний төрлүүд рүү сайн дурын үндсэн дээр шилжих хугацаа, нөхцөл, журмыг зохицуулсан “Газрын тосны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” бие даасан хуулийн төслийг хамт боловсруулж, өргөн мэдүүлнэ.

Түүнчлэн Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдан хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Газрын тосны тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг хүчингүй болсонд тооцох тухай болон Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулна.

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалт, борлуулалтын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах, хайгуулын хөрөнгө оруулалтын таатай эрх зүйн орчныг бүрдүүлэх, хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлж, нөөцийг нэмэгдүүлэх, дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр тогтвортой, найдвартай хангах, Үндэсний баялгийн санг арвижуулах, улсын эрчим хүчний аюулгүй байдал, бие даасан байдлыг бэхжүүлэхэд оршино.

2 дугаар зүйл.Газрын тосны тухай хууль тогтоомж

2.1.Газрын тосны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалт, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн байгууллага, албан тушаалтан, орон нутгийн засаг захиргааны харилцаанд энэ хууль үйлчилнэ.

3.2.Газрын тос, уламжлалт бус газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, хангамж, бөөний болон жижиглэнгийн борлуулалт, чанар, стандарт, аюулгүй байдалтай холбоотой харилцаанд энэ хууль үйлчлэхгүй.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“**ашиглалт**” гэж газрын тос, уламжлалт бус газрын тосны ордын нөөцийг баталгаажуулсны дараа хийгдэх ордын төлөвлөлт, хөгжүүлэлт, бүтээн байгуулалт, дэд бүтэц, олборлолт, бусад инженерийн цогц үйл ажиллагааг;

4.1.2.“**ашиглалтын талбай**” гэж гэрээлэгч болон газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага харилцан тохиролцож хэмжээ, хил заагийн булангийн цэгийн солбицлыг тогтоож, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ашиглалтын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн талбайг;

4.1.3.“**ашигт тос**” гэж хүргэлтийн цэг дээр хэмжсэн нийт тосноос өртөгт тос болон нөөц ашигласны төлбөр, борлуулалтын зардалтай тэнцэхүйц хэмжээний

тосыг хассаны дараа талуудын хооронд гэрээгээр тогтоосон хувь хэмжээгээр хуваарилах газрын тос, уламжлалт бус газрын тосыг;

4.1.4. **“борлуулалт”** гэж туршилтын олборлолтоор, эсхүл ашиглалтын шатанд олборлосон газрын тос, уламжлалт бус газрын тосыг хүргэлтийн цэгээс дотоодын боловсруулах үйлдвэрт эсхүл гадаад, дотоодын зах зээлд нийлүүлэх, арилжаалах үйл ажиллагааг;

4.1.5. **“борлуулалтын зардал”** гэж олборлосон газрын тос, уламжлалт бус газрын тосыг хэмжилтийн цэгээс хүргэлтийн цэг хүртэлх цуглуулах, хадгалах, шингэрүүлэх, шахах, тээвэрлэх, худалдах болон бусад холбогдох үйл ажиллагаанд зарцуулагдсан бодит өртгийг;

4.1.6. **“Бүтээгдэхүүн хуваах гэрээ”** гэж гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалт, олборлолтын үйл ажиллагааг өөрийн хөрөнгөөр эрсдэлийг бүрэн хариуцан гүйцэтгэх, энэ хуульд заасны дагуу борлуулсан тосноос нөөц ашигласны төлбөр, өртөгт тосыг хассаны дараах ашигт тосыг хуваарилах нөхцөлөөр эрх бүхий байгууллагатай байгуулсан эрх зүйн баримт бичгийг;

4.1.7. **“газрын тос”** гэж газрын хэвлийд болон агаарын хэвийн даралт, хэмд хатуу, шингэн, хийн төлөвт орших, байгалийн нүүрс-устөрөгчийн нэгдлүүдийн хольцыг;

4.1.8. **“Газрын тосны төрийн өмчит компани”** гэж газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаа эрхлэх, гэрээний дагуу төрд ногдох бүтээгдэхүүн, орлогыг удирдах, борлуулах болон хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах, газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, борлуулах үйл ажиллагаа эрхлэх чиг үүрэг бүхий төрийн өмчит хуулийн этгээдийг;

4.1.9. **“газрын тос, уламжлалт бус газрын тосны орд”** гэж геологийн хувьсал, өөрчлөлтөөр газрын хэвлийд үүссэн, чанар, нөөцийн хэмжээ нь Газрын тосны баялгийн менежментийн системийн шалгуураар тогтоогдсон газрын тос, уламжлалт бус газрын тосны хуримтлал бүхий бүтэц, давхарга зүйн онцлогоор төстэй нэг буюу хэд хэдэн хураагуурыг;

4.1.10. **“газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаа”** гэж газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт, татан буулгалт болон гэрээт талбайг буцаан өгөхтэй холбогдсон үйл ажиллагааг;

4.1.11. **“Газрын тосны баялгийн менежментийн систем”** гэж олон улсын газрын тосны инженерүүдийн холбоо болон холбогдох олон улсын байгууллагуудаас баталсан, тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй газрын тосны баялаг, нөөцийн ангилал, тооцоолол, төслийн арилжааны үнэлгээний нийтлэг аргачлалыг;

4.1.12. **“гэрээ”** гэж газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах талаар талуудын хооронд байгуулсан энэ хуульд заасан гэрээний төрлүүдийг;

4.1.13. **“гэрээлэгч”** гэж энэ хуульд заасан гэрээний аль нэгийг эрх бүхий байгууллагатай байгуулсан, гэрээт талбайд газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаа эрхэлж буй дотоод, гадаадын хуулийн этгээд /компани/, эсхүл тэдгээрийн нэгдлийг;

4.1.14. **“гэрээт талбай”** гэж газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахаар гэрээгээр зааглан тогтоосон талбайг;

4.1.15. **“дэд бүтэц”** гэж ордын хөгжүүлэлт, бүтээн байгуулалт болон олборлолтын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах зориулалттай авто зам, гүүр, цахилгаан хангамж, холбоо, ус хангамж, бохир усны систем, дулаан хангамж, ажилчдын болон үйлдвэрлэлийн туслах байгууламж, агуулах болон тэдгээртэй холбоотой инженерийн шугам сүлжээ, байгууламжийг;

4.1.16. **“нөөц ашигласны төлбөр”** гэж борлуулалтын орлогоос тооцож, төрийн нийтийн өмчийн баялгийг ашигласны төлөө Төсвийн тухай хуульд заасны дагуу биет, эсхүл мөнгөн хэлбэрээр төрд төлөх үл хасагдах төлбөрийг;

4.1.17. **“нүүрсний давхаргын метан хий”** гэж нүүрсжих явцад үүсэж, нүүрсний давхарга дотор эсхүл нүүрс агуулсан болон түүнтэй ойр орших геологийн тогтоц, чулуулгийн нүх сүв, ан цав, хураагуурт байгалийн жамаар хуримтлагдсан метан давамгайлсан нүүрс-устөрөгчийн хийг;

4.1.18. **“нүүрсний уурхайн метан хий”** гэж нүүрсний уурхай ашиглалтын явцад аюулгүй ажиллагааг хангах, агааржуулалт, хий зайлуулах, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор нүүрсний уурхайн малталт, олборлолтын бүсэд илэрсэн, зайлуулсан, эсхүл цуглуулсан метан хийг;

4.1.19. **“нээлт”** гэж газрын тосны хувьд хайгуулын өрөмдлөг, цооногийн болон олборлолтын туршилтаар тухайн талбайд хөдөлгөөнт нүүрс-устөрөгчийн хуримтлалыг анхлан тогтоосон үр дүнг; уламжлалт бус газрын тосны хувьд хайгуулын өрөмдлөг, дээжлэлт, цооногийн туршилт, каротаж, лабораторийн шинжилгээ болон бусад техникийн өгөгдлөөр хөдөлгөөнт нүүрс-устөрөгчийн хуримтлалд олборлолтын туршилтаар хийн урсгал байгааг тогтоосон үр дүнг; нүүрсний давхаргын метан хийн хувьд нэг буюу түүнээс дээш цооногоор нүүрсний давхаргын метан хийн хуримтлал оршиж байгааг нэг буюу хэд хэдэн техникийн болон инженер-геологийн өгөгдлөөр тогтоосон үр дүнг;

4.1.20. **“нээлтийн цооног”** гэж энэ зүйлийн 4.1.18-д заасан нээлтийг анхлан илрүүлсэн цооногийг;

4.1.21. **“олборлолт”** гэж газрын хэвлийгээс газрын тос, уламжлалт бус газрын тосыг газрын гадаргуу дээр гарган авах, цуглуулах, анхан шатны боловсруулалт хийх, хийг шахах, шингэрүүлэх, хураагуурын даралтыг дэмжих, туршилт, шингэн хагалбар, засвар үйлчилгээ хийх зэрэг цогц үйл ажиллагааг;

4.1.22. **“олборлолтын зардал”** гэж ордын хөгжүүлэлт, татан буулгалтын зардлаас бусад олборлолтын үйл ажиллагаанд хамаарах бүх зардлыг;

4.1.23. **“олборлолтын туршилт”** гэж газрын тосны хувьд нээлт хийгдсэн газрын тосны хуримтлалд өрөмдсөн цооногоос тодорхой хугацаанд олборлолт явуулж, тос, хий, усны гарц, цооногийн ёроолын урсгалын даралт, даралтын бууралт, флюидын харьцаа, цооногийн бүтээмж, хураагуурын урсгалын төлөв болон урт хугацааны олборлолтын боломжийг тодорхойлох туршилтын үйл ажиллагааг; уламжлалт бус газрын тосны хувьд үнэлгээний явцад нэг буюу цөөн тооны цооногоор тодорхой хугацаанд бодит ус шавхалт, даралтын бууралт, метан хийн десорбц, хий-усны олборлолтын динамик, хий-усны харьцаа, хийн олборлолтын өсөлт, усны бууралт болон цооногийн бүтээмжийг тодорхойлох зорилгоор явуулах туршилтын үйл ажиллагааг;

4.1.24. **“оператор”** гэж гэрээлэгчийн нэрийн өмнөөс газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, Монгол Улсад бүртгэлтэй, татвар төлөгч хуулийн этгээдийг;

4.1.25. **“Ордын хөгжүүлэлт”** гэж газрын тос, уламжлалт бус газрын тосны ордыг олборлолтод бэлтгэх, олборлолтыг төлөвлөсөн түвшинд хүргэх, үр ашигтай, аюулгүй явуулах зорилгоор батлагдсан орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хөгжүүлэлтийн цооног өрөмдөх, цооногийн гүйцээлт хийх, туршилтын олборлолт явуулах, олборлолт нэмэгдүүлэх нэмэлт ажилбар хэрэгжүүлэх, олборлолтын болон шахалтын систем байгуулах, хураагуур болон олборлолтын горимыг удирдах, олборлосон усны менежмент хэрэгжүүлэх, түүнчлэн газрын тос олборлох, цуглуулах, анхан шатны боловсруулалт хийх, хадгалах, хэмжих, шахах, шингэрүүлэх, дамжуулах, олборлосон усыг цуглуулах, цэвэршүүлэх, зайлуулах болон бусад технологийн зориулалттай гадаргуугийн болон газрын доорх байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээ, тэдгээрийн үйл ажиллагааг хангах дэд бүтцийн объектыг шинээр барих, суурилуулах, угсрах болон эдгээртэй холбоотой инженер, технологи, зохион байгуулалтын цогц үйл ажиллагааг;

4.1.26. **“Ордын хөгжүүлэлт”** гэж газрын тосны ордыг олборлолтод бэлтгэх, олборлолтыг төлөвлөсөн түвшинд хүргэх, үр ашигтай явуулах зорилгоор батлагдсан орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хөгжүүлэлтийн цооног өрөмдөх, цооногийн гүйцээлт хийх, туршилтын олборлолт явуулах, олборлолт нэмэгдүүлэх нэмэлт ажилбар хийх, олборлолтын болон шахалтын систем байгуулах, бүтээн байгуулалт хийх, хураагуур болон олборлолтын горимыг удирдах, олборлосон усны менежмент хэрэгжүүлэх, дэд бүтэц байгуулах болон тэдгээртэй холбоотой инженер, технологи, зохион байгуулалтын цогц үйл ажиллагааг;

4.1.27. **“Орлого хуваах гэрээ”** гэж гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг өөрийн хөрөнгөөр эрсдэлийг бүрэн хариуцан гүйцэтгэх, борлуулалтын нийт орлогыг гэрээгээр тогтоосон хувь хэмжээгээр хуваарилах нөхцөл бүхий эрх бүхий байгууллагатай байгуулах эрх зүйн баримт бичгийг;

4.1.28. **“өртөг нөхөх зардал”** гэрээ, хууль болон холбогдох журмын дагуу гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зарцуулсан, олборлолтын бүтээгдэхүүн эсхүл борлуулалтын орлогоос нөхөн авах эрхтэй гэж эрх бүхий байгууллагын хянаж, баталгаажуулсан зардлыг;

4.1.29. **“өртөгт тос”** гэж өртөг нөхөх зардлыг буцаан олгоход зориулж, хүргэлтийн цэг дээр хэмжиж борлуулсан газрын тос, уламжлалт бус газрын тосноос хууль болон гэрээнд заасан хувь хэмжээгээр тооцсон гэрээлэгчид ногдох тосыг;

4.1.30. **“Талбай хамтран ашиглах гэрээ”** гэж ашигт малтмалын бусад төрлийн тусгай зөвшөөрөл бүхий талбайтай гэрээт талбай давхацсан тохиолдолд талууд үйл ажиллагааны дараалал, хугацааны график, хөдөлмөрийн аюулгүй байдлыг харилцан уялдуулж, хамтран ажиллахаар байгуулсан эрх зүйн баримт бичгийг;

4.1.31. **“талбайн хэсэгчилсэн буцаалт”** гэж хайгуулын үндсэн болон сунгасан хугацааны үе шатуудад үр ашигтай нээлт хийгдээгүй, хэтийн төлөвгүй гэрээт талбайн хэсгийг хууль болон гэрээнд заасан хувь хэмжээгээр үе шаттай буцаан өгөх үйл явцыг;

4.1.32. **“татан буулгалт”** гэж гэрээний хугацаа дуусгавар болсон, цуцлагдсан, эсхүл гэрээт талбайг бүхэлд нь буюу хэсэгчлэн буцаан өгөх үед гэрээлэгчээс цооногуудыг хаах, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг буулгах,

нүүлгэн шилжүүлэх, хог хаягдлыг зайлуулах болон байгаль орчныг нөхөн сэргээх цогц үйл ажиллагааг;

4.1.33. **“татан буулгалтын зардал”** гэж энэ хуульд заасан татан буулгалтын үйл ажиллагаанд зарцуулах мөнгөн хөрөнгийг;

4.1.34. **“Татвар-нөөц ашигласны төлбөрийн гэрээ”** гэж гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг өөрийн хөрөнгөөр эрсдэлийг бүрэн хариуцан гүйцэтгэх, олборлосон тосыг өөрийн өмчлөлд авч захиран зарцуулах, нөөц ашигласны төлбөр болон татварыг мөнгөн хэлбэрээр төлөх нөхцөл бүхий эрх бүхий байгууллагатай байгуулах эрх зүйн баримт бичгийг;

4.1.35. **“тос”** гэж уламжлалт болон уламжлалт бус газрын тосыг;

4.1.36. **“туршилтын олборлолт”** гэж үнэлгээний үр дүнг баталгаажуулах, хураагуурын загварыг шалгаж, тохируулах, цооног хоорондын даралтын харилцан нөлөөлөл, шүүрлийн талбай, цооногийн хоорондын зай, ус шавхалтын стратеги, олборлолтын урьдчилсан таамаглал, эдийн засгийн боломж болон ордын хөгжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулах үндэслэлийг тогтоох зорилгоор хэд хэдэн цооногийг хамруулан хугацаатайгаар явуулах олборлолтын үйл ажиллагааг;

4.1.37. **“туслан гүйцэтгэгч”** гэж газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны тодорхой хэсгийг хэрэгжүүлэх, ажил, үйлчилгээ үзүүлэхээр гэрээлэгч, эсхүл оператортой гэрээ байгуулсан, Монгол Улсад бүртгэлтэй, татвар төлөгч хуулийн этгээд, иргэн, мөн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч гадаад, дотоодын хуулийн этгээд, иргэнийг;

4.1.38. **“уламжлалт бус газрын тос”** гэж байгалийн урсгалгүй, нэвчүүлэмж маш багатай занар, үүсгэгч чулуу, элсэн чулуу, эсхүл нүүрсний давхаргад орших, олборлоход уламжлалт арга, аргачлалаас өөр технологийн шийдэл, үйл ажиллагаа шаарддаг, нүүрсний давхаргын метан хий, байгалийн битум, шатдаг занар, тослог элс, хийтэй элс, хий, занар ба бусад;

4.1.39. **“үнэлгээ”** гэж нээлтийн цооногоор илрүүлсэн газрын тос, уламжлалт бус газрын тосны хуримтлалын хэмжээ, шинж чанар, хил заагийг нарийвчлан тогтоох, Газрын тосны баялгийн менежментийн системийн дагуу үр ашигтай нээлт мөн эсэхийг тодорхойлох зорилгоор хайгуулын шатанд гүйцэтгэх цогц үйл ажиллагааг;

4.1.40. **“үр ашигтай нээлт”** гэж хайгуулын ажлын үр дүнд тухайн үеийн техник, технологийг ашиглан эдийн засгийн үр ашигтайгаар олборлох боломжтой нь тогтоогдсон нээлтийг;

4.1.41. **“хайгуул”** гэж газрын тос, уламжлалт бус газрын тосны хуримтлалыг илрүүлэх, үнэлэх, нөөцийн хэмжээг тогтоох зорилгоор гүйцэтгэх геологи, геохими, геофизик, өрөмдлөг, цооногийн туршилт, олборлолтын туршилт, туршилтын олборлолт явуулах цогц үйл ажиллагааг;

4.1.42. **“хайгуулын ажлын доод хэмжээ”** гэж газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээгээр гэрээлэгчийн хайгуулын хугацаанд хэрэгжүүлэхээр хүлээсэн, биелэлтийг хайгуулын хугацааны нийт дүнгээр хуримтлуулан тооцож, тухайн жилийн илүү болон дутуу гүйцэтгэлийг дараагийн жилүүдэд шилжүүлэн тооцох ажлын хэмжээгээр тодорхойлогдсон нийт доод хэмжээг;

4.1.43. **“хайгуулын ажлын зардал”** гэж энэ хуульд заасан хайгуул, үнэлгээтэй холбогдон гарах зардлын нийлбэрийг;

4.1.44. **“хайгуулын талбай”** гэж газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас нээлттэй сонгон шалгаруулалтаар зарласан, эсхүл гэрээгээр гэрээлэгчид олгосон талбайг;

4.1.45. **“Хамтын ажиллагааны гурвалсан гэрээ”** гэж газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, гэрээлэгч болон гэрээт талбай байрших сум, дүүргийн Засаг даргын хооронд байгуулах, орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдийн нийгмийн хамгаалалд дэмжлэг үзүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх талаар харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулсан эрх зүйн баримт бичгийг;

4.1.46. **“Хамтарсан хөрөнгө оруулалтын гэрээ”** гэж Газрын тосны төрийн өмчит компани болон гэрээлэгчийн хооронд гэрээт талбайд газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх зорилгоор талуудын оролцооны хувь, хөрөнгө оруулалт, зардал, эрсдэл, эрх үүрэг, олборлох бүтээгдэхүүн болон орлогын хуваарилалтыг зохицуулсан эрх зүйн баримт бичгийг;

4.1.47. **“хүргэлтийн цэг”** гэж Засгийн газар болон гэрээлэгчид гэрээний дагуу ногдох газрын тос, уламжлалт бус газрын тосыг хэмжиж хуваах цэгийг;

4.1.48. **“хэмжилтийн цэг”** гэж гэрээт талбайд газрын тос, уламжлалт бус газрын тосыг худалдах зорилгоор ачилт хийх үед хэмжсэн цэгийг;

4.1.49. **“ялгасан талбай”** гэж газрын тос, уламжлалт бус газрын тосны хуримтлал байж болох хэтийн төлөвтэй гэж үзэн хайгуул хийхээр газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тодорхойлсон талбайг;

5 дугаар зүйл. Газрын тос, уламжлалт бус газрын тосны өмчлөл

5.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн газрын хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа газрын тос, уламжлалт бус газрын тос нь төрийн нийтийн өмч байна.

5.2. Энэ хуульд заасан газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад цугларсан геологи, геофизик, геохими, өрөмдлөгийн болон бусад анхдагч мэдээ материал болон үр дүнгийн мэдээлэл, өгөгдөл, тайлан, дээж, сорьц, түүний шинжилгээний үр дүн нь төрийн өмч байх ба гэрээлэгч нь гэрээний хугацаанд уг мэдээллийг ашиглах, нууцлалыг хадгалах онцгой эрхтэй байна.

5.3. Гэрээлэгч нь энэ хууль болон гэрээнд заасны дагуу хүргэлтийн цэг дээр хэмжиж баталгаажуулсан газрын тос, уламжлалт бус газрын тосноос өөрт ногдох тосыг эзэмших, ашиглах, олон улсын зах зээлд болон дотоодод хууль ёсны дагуу захиран зарцуулах онцгой эрхтэй байна.

6 дугаар зүйл. Газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд баримтлах зарчим

6.1. Газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

6.1.1. үндэсний язгуур ашиг сонирхлыг дээдэлж, төр, хөрөнгө оруулагч, орон нутгийн хамтын ашиг сонирхлын тэнцвэрийг хангах, Үндэсний баялгийн санд төвлөрөх орлогыг нэмэгдүүлэх;

6.1.2.байгаль орчныг хамгаалах, газрын хэвлийн баялгийг зохистой, үр ашигтай ашиглах, нөхөн сэргээлтийг олон улсын болон үндэсний стандартын дагуу хэрэгжүүлэх;

6.1.3.чөлөөт зах зээлийн зарчмыг баримталж, газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой байдлыг хангах, гэрээлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

6.1.4.тусгай зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах, сонгон шалгаруулах ажиллагааг ил тод, шударга, өрсөлдөөний тэгш нөхцөлд явуулж, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдыг ялгаварлан гадуурхахгүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

6.1.5.газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд олон улсын дэвшилтэт техник, технологи, арга, аргачлал, хэмжил зүйн нэгдсэн стандартыг нэвтрүүлэх;

6.1.6.үндэсний ажиллах хүчнийг бэлтгэх, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих;

6.1.7.газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааг уур амьсгалын өөрчлөлтийн талаарх төрийн бодлого, олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцүүлэн хэрэгжүүлэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

7 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

7.1.Улсын Их Хурал газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.газрын тос, уламжлалт бус газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг батлах;

7.1.2.Засгийн газрын өргөн мэдүүлснээр газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахыг хориглосон, эсхүл хязгаарласан нутаг дэвсгэрийн хилийн заагийг тогтоох, өөрчлөх;

7.1.3.газрын тосны тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих.

8 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

8.1.Засгийн газар газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.газрын тосны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах;

8.1.2.газрын тос, уламжлалт бус газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан бодлогын хэрэгжилтийг хангах;

8.1.3.энэ хуульд заасан гэрээний ерөнхий загвар, газрын тос, уламжлалт бус газрын тосны бүртгэл, тооцооны журам, нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам болон уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдох харилцааг зохицуулах тухай журмыг батлах;

8.1.4.нөөц ашигласны төлбөр болон Засгийн газарт ногдох ашигт тосыг биет бүтээгдэхүүн болон мөнгөн хэлбэрээр төвлөрүүлэх, хуваарилах, зарцуулах асуудлыг шийдвэрлэх;

8.1.5.дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр тогтвортой хангах зорилгоор гэрээлэгчид ногдох тосыг тэргүүн ээлжинд зах зээлийн жишиг үнээр худалдан авах төрийн давуу эрхийг эдлэх;

8.1.6.улсын хил дамнасан газрын тос, уламжлалт бус газрын тосны хуримтлал бүхий хураагуур, орд тогтоогдсон тохиолдолд түүнийг ашиглах асуудлыг Засгийн газар хоорондын гэрээгээр зохицуулах;

8.1.7.улсын хилийн зурвас, тусгай хэрэгцээний газарт газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

8.1.8.газрын тос, уламжлалт бус газрын тосны ордын хөгжүүлэлтийн болон ашиглалтын талбайг энэ хууль болон гэрээлэгчтэй харилцан тохиролцсон хэмжээгээр улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах;

8.1.9.гэрээт талбай нь бусад ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын талбайтай давхцсан тохиолдолд талуудын хамтын ажиллагааны удирдамж, үйл ажиллагааны эрэмбийг улс орны нийгэм, эдийн засгийн ач холбогдол болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг нь үндэслэн шийдвэрлэх;

8.1.10.газрын тос, уламжлалт бус газрын тос борлуулах зориулалт бүхий дамжуулах хоолой барих зөвшөөрөл олгох.

8.2.Энэ хуулийн 8.1.3-т заасан журмаар дараах харилцааны хүрээ, агуулгыг нарийвчлан зохицуулна:

8.2.1.газрын тос, уламжлалт бус газрын тосны бүртгэл, тооцооны журмаар Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгч, эсхүл оператор компанийн газрын тостой холбогдсон үйл ажиллагааг бүртгэх, тооцох, тайлагнах арга зүйг тодорхойлох, зохицуулах харилцааг;

8.2.2.нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журмаар газрын тосны нөөц ашигласны төлбөр болон хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг;

8.2.3.уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдох харилцааг зохицуулах журмаар уламжлалт бус газрын тос эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг тус тус тогтооно.

9 дүгээр зүйл.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

9.1.Газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.газрын тос, уламжлалт бус газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогын төслийг боловсруулах;

9.1.2.газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

9.1.3.энэ хуульд заасан гэрээг байгуулах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах болон гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг шилжүүлэх эрхийг төрийн захиргааны байгууллагад олгох;

9.1.4.Газрын тосны төрийн өмчит компани газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг гадаад, дотоодын аж ахуйн нэгжтэй хамтран явуулах гэрээ байгуулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах болон гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг шилжүүлэх эрхийг олгох;

9.1.5.Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

9.1.6.газрын тос, уламжлалт бус газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайлан, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайлан, орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах аргачлал, газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах, сургалтын урамшуулал, мэргэжлийн зэрэг олгох журмыг батлах;

9.1.7.газрын тос, уламжлалт бус газрын тосны нөөцийн тооцооны тайлан, орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулах, шийдвэр гаргах;

9.1.8.газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;

9.1.9.газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг хүлээн авах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;

9.1.10.Газрын тосны төрийн өмчит компанид газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын болон ашиглалтын талбайг нээлттэй сонгон шалгаруулалтгүйгээр, давуу эрхээр олгох асуудлыг шийдвэрлэх;

9.1.11.газрын тос борлуулах зориулалт бүхий дамжуулах хоолой барих саналыг Засгийн газарт өргөн мэдүүлэх;

9.2.Энэ хуулийн 9.1.6-д заасан журмаар дараах харилцааны хүрээ, агуулгыг нарийвчлан зохицуулна:

9.2.1.баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага, газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах аргачлал болон хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлагаар газрын тосны хайгуулын ажлын үр дүн, баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооллын материалуудыг нэгтгэн боловсруулах, газрын тос, уламжлалт бус газрын тосны ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад тавигдах шаардлага, газрын тос, уламжлалт

бус газрын тосны чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын анхдагч болон боловсруулалт, тайлал хийсэн материал, үр дүнгийн тайланг боловсруулах аргачлалыг;

9.2.2.хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журмаар газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан авахтай холбогдсон харилцааг;

9.2.3.сургалтын урамшууллын болон салбарын мэргэжлийн зэрэг олгох журмаар сургалтын урамшууллын хөрөнгийг зарцуулах, сургалтын дансны хөрөнгөөр суралцах иргэдийг сонгон шалгаруулах, газрын тосны салбарын инженерүүдэд мэргэжлийн зэрэг олгох, түүнийг төрийн эрх бүхий байгууллагаас баталгаажуулж, хяналт тавихтай холбогдсон харилцааг тус тус тогтооно.

9.3.Энэ хуулийн 9.1.8-д заасан дүрмээр газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд баримтлах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны суурь шаардлагыг тус тус тогтооно.

9.4.Энэ хуулийн 9.1.9-д заасан журмаар газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн газарт байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг хүлээн авах харилцааг нарийвчлан тогтооно.

10 дугаар зүйл.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

10.1.Газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд хангах;

10.1.2.ялгасан талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах, захиалга хүлээн авах, сонгон шалгаруулах;

10.1.3.гэрээлэгчтэй байгуулсан гэрээний төрлийг өөрчлөх болон тухайн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргах;

10.1.4.газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн хүрээнд гэрээлэгчтэй гэрээ байгуулах, түүний биелэлтэд хяналт тавих;

10.1.5.гэрээлэгчийн тухайн жилийн ажлын төлөвлөгөө, төсвийг хянаж батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

10.1.6.гэрээлэгчийн хайгуулын ажлын доод хэмжээний гүйцэтгэлийг хянаж баталгаажуулах;

10.1.7.газрын тос, уламжлалт бус газрын тосны нөөцийн хөдөлгөөнийг хянах, ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлэх;

10.1.8.ашиглалтын талбайн хэмжээ, түүний хилийн заагийн булангийн цэгийн солбицлыг гэрээлэгчтэй харилцан тохиролцож, хамтран баталгаажуулах;

10.1.9.гэрээлэгчийн тухайн жилийн өртөг нөхөх зардал, нөөц ашигласны төлбөр, өртөгт тос, ашигт тос, олборлосон болон борлуулсан газрын тос, уламжлалт бус газрын тосны тайланг хүлээн авч нэгтгэх, хянах;

10.1.10.хүргэлтийн цэг болон хэмжилтийн цэгийн байршил, техникийн нөхцөлийг гэрээлэгчтэй харилцан тохиролцож тогтоох;

10.1.11.газрын тос, уламжлалт бус газрын тосны борлуулалтын орлогоос Засгийн газарт ногдох орлого, энэ хуульд болон гэрээнд заасан төлбөр, урамшууллыг биет болон мөнгөн хэлбэрээр төсөвт төвлөрүүлэх;

10.1.12.газрын тосны хайгуул, ашиглалтын чиглэлээр эрдэм шинжилгээний болон сэдэвчилсэн судалгаа хийх;

10.1.13.гэрээт талбайд гүйцэтгэсэн газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон үйл ажиллагааны анхдагч мэдээ материал болон үр дүнгийн мэдээлэл, өгөгдөл, тайлан, дээж, сорьц, түүний шинжилгээний үр дүнг хянаж хүлээн авах, бүртгэх, цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;

10.1.14.гэрээт талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан авах, татан буулгах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулах;

10.1.15.байгалийн байдлаараа оршиж байгаа газрын тос, уламжлалт бус газрын тосны хураагуурын орон зайд газрын тос, уламжлалт бус газрын тос хадгалах зөвшөөрөл олгох;

10.1.16.газрын тос, уламжлалт бус газрын тосны хуримтлал, орд нь хоёр ба түүнээс дээш гэрээт талбайг дамнасан тохиолдолд энэ хуулийн 33.4, 33.5-д заасны дагуу зохицуулах;

10.1.17.Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх хайгуул, ашиглалттай холбогдсон ажлын даалгаврыг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан хянаж, хариу өгөх ба энэ хугацаанд хариу өгөөгүй бол уг ажлын даалгаврыг хянаж зөвшөөрсөнд тооцох;

10.1.18.гэрээлэгчийн хууль бус үйл ажиллагаа, эсхүл техникийн болон байгаль орчны ноцтой эрсдэл үүссэн тохиолдолд газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түр хугацаагаар зогсоох шийдвэр гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад нэн даруй мэдэгдэх;

10.1.19.Газрын тосны төрийн өмчит компанид олгогдсон талбайн хайгуулын ажлын анхдагч болон боловсруулалт хийгдсэн өгөгдөл, тайлан, материалыг цахим хэлбэрээр үнэ төлбөргүй хуулбарлан өгөх;

10.1.20.гэрээлэгчтэй төрийг төлөөлөн харилцах нэг цонхны үйлчилгээ үзүүлж, төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, зохицуулалтыг хангах;

10.1.21.хууль болон гэрээнд заасан бүрэн эрхээ шударга, ил тод, хугацаанд нь хэрэгжүүлж, төрийн байгууллага хоорондын зохицуулалт, чиг үүргийн давхардлаас үүсэх хүндрэл, саатлыг гэрээлэгчид шилжүүлэхгүй байх;

10.1.22.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

11 дүгээр зүйл.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын бүрэн эрх

11.1.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.хууль тогтоомжоор өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улсын ашиг сонирхлыг харгалзаж, гаргах шийдвэрээ улсын хөгжлийн бодлоготой уялдуулах;

11.1.2.төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн газрын тос, уламжлалт бус газрын тосны ялгасан талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай мэдэгдлийг хүлээн авч, 30 хоногийн дотор санал гаргах;

11.1.3.энэ хуулийн 11.1.2-т заасан хугацаанд санал ирүүлээгүй бол дэмжсэн саналд тооцох;

11.1.4.энэ хуулийн 11.1.2-т заасан саналыг гаргахдаа зөвхөн хуулиар үйл ажиллагаа явуулахыг хориглосон, эсхүл хязгаарласан үндэслэлээр татгалзах;

11.1.5.татан буулгалтын ажлын үр дүнг хүлээн авах комиссын үйл ажиллагаанд оролцох, хамтран ажиллах;

11.2.Аймгийн Засаг дарга газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.2.1.газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

11.2.2.хайгуул, ашиглалтын талбайд зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагатай үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах;

11.2.3.энэ хуульд заасан Хамтын ажиллагааны гурвалсан гэрээний хэрэгжилт болон тухайн гэрээнд заасан мөнгөн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих;

11.2.4.газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны явц, байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлтийн мэдээллийг нийтэд тогтмол мэдээлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах;

11.2.5.Хамтын ажиллагааны гурвалсан гэрээний хэрэгжилтийн тайлан, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, олон нийтэд мэдээлэх.

11.3.Сум, дүүргийн Засаг дарга газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.3.1.газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн биелэлтийг хангах, гэрээлэгчид дэмжлэг үзүүлэх;

11.3.2.харьяалах нутаг дэвсгэртээ тусгай зөвшөөрлөөр олгогдсон гэрээт талбайг зориулалтаар нь ашиглахад хяналт тавих, хууль бус үйл ажиллагаа, зөрчил гаргавал таслан зогсоох, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх;

11.3.3.гэрээлэгч, оператор, туслан гүйцэтгэгч компанийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлт, ус ашиглалт, хаягдлын менежментийн

хэрэгжилт болон хүн амын эрүүл мэндийг хамгаалах үүргийн биелэлтэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих;

11.3.4.Хамтын ажиллагааны гурвалсан гэрээг байгуулах, хэрэгжилтийг хангах, тайланг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон дээд шатны Засаг даргад жил бүр хүргүүлэх;

11.3.5.газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар иргэд, олон нийтээс ирүүлсэн санал, гомдлыг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;

11.3.6.осол, байгаль орчны бохирдол, үйлдвэрлэлийн аваар гарсан тохиолдолд төрийн эрх бүхий байгууллага, гэрээлэгч, оператор компанитай хамтран шуурхай арга хэмжээ авах.

11.4.Баг, хорооны Засаг дарга газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.4.1.газрын тосны тухай хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцах;

11.4.2.гэрээлэгч, оператор компани хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар сум, дүүргийн Засаг даргад санал хүргүүлэх;

11.4.3.Хамтын ажиллагааны гурвалсан гэрээний төсөлд нутгийн иргэдийн ашиг сонирхлыг тусгах талаар санал өгөх;

11.4.4.газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны талаар нутгийн иргэдийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, иргэдээс гарсан саналыг сум, дүүргийн Засаг дарга болон холбогдох байгууллагад уламжлах.

11.5. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, багийн иргэдийн Нийтийн Хурал газрын тосны тухай болон бусад хууль тогтоомжоор өөрт нь ногдуулсан орон нутгийн эрх хэмжээний асуудлыг шийдвэрлэхдээ улсын ашиг сонирхлыг харгалзаж, бодлого, шийдвэрээ төрийн бодлоготой уялдуулна.

11.6.Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, Засаг дарга нь газрын тос, уламжлалт бус газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан хүсэлтийг хуульд заасан хугацаанд шийдвэрлэх бөгөөд хуульд заасан үндэслэлээс бусад тохиолдолд татгалзахыг хориглоно.

11.7.Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, Засаг дарга нь газрын тос, уламжлалт бус газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд хэвийн хэрэгжүүлэхэд төрийн үйлчилгээ, захиргааны шийдвэрийг шуурхай үзүүлэх, байгууллага хоорондын уялдаа холбоог хангах замаар дэмжлэг үзүүлнэ.

12 дугаар зүйл.Газрын тосны төрийн өмчит компанийн бүрэн эрх

12.1.Газрын тосны төрийн өмчит компани нь Засгийн газрын шийдвэрээр байгуулагдсан, Компанийн тухай хуулийн дагуу арилжааны үйл ажиллагаа эрхлэх, төрийн өмчит хуулийн этгээд байна.

12.2.Газрын тосны төрийн өмчит компани нь хувийн эрх зүйн харилцаанд бие даан оролцох бөгөөд үйл ажиллагааныхаа үр дүнгээр хүлээх хариуцлагыг өөрийн хөрөнгөөр хариуцна.

12.3.Газрын тосны төрийн өмчит компани газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.3.1.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн дагуу энэ хуульд заасан газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах гэрээнд төрийн өмчийн ногдох хувь хэмжээг эзэмших, Засгийн газрыг төлөөлөн гэрээний оролцогч тал болох;

12.3.2.гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тос, уламжлалт бус газрын тосыг хүргэлтийн цэг дээр хүлээн авах, хадгалах, тээвэрлэх болон дотоод, гадаадын зах зээлд борлуулах ажлыг гүйцэтгэх;

12.3.3.газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд компанийн засаглалын зарчмыг баримтлан, зах зээлийн бусад оролцогчтой эрх тэгш өрсөлдөх;

12.3.4.газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын гэрээгээр хүлээсэн үүргээ өөрт ногдох эзэмшлийн хувь хэмжээнд нийцүүлэн бие даан хариуцах;

12.3.5.Газрын тосны төрийн өмчит компани нь үйл ажиллагаандаа шаардагдах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгохдоо Монгол Улсад бүртгэлтэй, дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид хууль тогтоомжийн дагуу давуу эрх олгох.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ГЭРЭЭЛЭГЧ, ОПЕРАТОР КОМПАНИ, ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

13 дугаар зүйл.Гэрээлэгчийн эрх

13.1.Гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны хүрээнд дараах эрхийг эдэлнэ:

13.1.1.гэрээний нөхцөлийн дагуу өөрт ногдох газрын тос, уламжлалт бус газрын тосыг хүргэлтийн цэг дээр захиран зарцуулах;

13.1.2.гэрээлэгч энэ хуульд заасан гэрээний төрлийг сонгох, гэрээний төрлийг өөрчлөх, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах;

13.1.3.гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ энэ хуульд заасан журмын дагуу бусдад шилжүүлэх;

13.1.4.шаардлагатай тохиолдолд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлөөр үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах;

13.1.5.энэ хуульд заасан татан буулгалтын ажлыг бүрэн биелүүлж, актыг баталгаажуулсан тохиолдолд Монгол Улсын арилжааны банкны хадгаламжийн дансанд байршуулсан үлдэгдэл мөнгөн хөрөнгийг буцаан авах;

13.1.6.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ бүрэн биелүүлсэн тохиолдолд хайгуулын талбайг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн буцаах;

13.1.7.Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан тохиолдолд гэрээлэгчийн захиргааны зардал нь тухайн жилийн өртөг нөхөх зардлын тав хүртэл хувь байх;

13.1.8.энэ хуульд заасан татан буулгалтын зардлын баталгааны төлбөрөөс хүү тооцох хүсэлт гаргах;

13.1.9. газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үед хийгдэх цооногийн өрөмдлөг, гүйцээлт, перфораци, каротаж, туршилт, шингэн хагалбар, олборлолтын туршилт, туршилтын олборлолтын үед ашиглах тоног төхөөрөмж, түр барилга байгууламж (газрын тос, хийн цооногийн байгууламж, цооногийн дэргэдэх хадгалах сав, шугам хоолой)-ийг барьж ашиглах;

13.1.10.төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбоотойгоор санал, хүсэлт, шаардлага гаргах;

13.1.11.туслан гүйцэтгэгчийг энэ хуулийн 16.1-д заасан шаардлагад нийцүүлэн бие даан сонгон шалгаруулах.

14 дүгээр зүйл.Гэрээлэгчийн нийтлэг үүрэг

14.1.Гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны хүрээнд дараах үүргийг хүлээнэ:

14.1.1.Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын стандарт, техникийн зохицуулалтыг мөрдөж, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх;

14.1.2.үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, төсвийг төрийн захиргааны байгууллагаар батлуулж хэрэгжүүлэх;

14.1.3.Засгийн газар хуульд заасан давуу эрхээ эдлэх тохиолдолд бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлийн жишиг үнэ, нөхцөлөөр дотоодын үйлдвэрт тэргүүн ээлжинд нийлүүлэх;

14.1.4.өөрийн үйл ажиллагаанд шаардагдах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгохдоо Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгч аж ахуйн нэгжид тэргүүн ээлжинд давуу эрх олгох;

14.1.5.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг стандартын дагуу бүрэн хийж дуусгах, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах ажлын зардлыг гаргах;

14.1.6.ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь татан буулгалтын зардлын баталгаа болгон гэрээлэгчид ногдох ашигт тосны 1 хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө, төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсын арилжааны банкны хадгаламжийн дансанд байршуулах;

14.1.7.энэ хуулийн 14.1.6-д заасан татан буулгалтын зардлын баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулах, зарцуулах харилцааг зохицуулсан гэрээг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, банк болон гэрээлэгч, эсхүл түүний оператор хамтран байгуулах;

14.1.8.хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд шаардагдах автомашин, техник, тоног төхөөрөмж, материал түүхий эд, сэлбэг хэрэгсэл, газрын тосны

бүтээгдэхүүнийг импортлох тухай бүрд тэдгээрийн нэр төрөл, тоо хэмжээ, нэгж үнийн мэдээлэл, техникийн баримт бичиг болон ашиглалтын үе шатанд баригдах барилга байгууламжийн зураг төслийг төрийн захиргааны байгууллагад гаргаж өгөх;

14.1.9.төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр хайгуул, ашиглалттай холбогдсон анхдагч болон үр дүнгийн тайлан, материалыг гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх;

14.1.10.газрын тос, уламжлалт бус газрын тосны нөөцийн хөдөлгөөний тооцоог жил бүр гаргаж, төрийн захиргааны байгууллагаар хянуулж баталгаажуулах;

14.1.11.санхүүгийн тайлан, өртөг нөхөх зардлын тайлан, бүтээгдэхүүн хуваах тооцоог хууль тогтоомжид заасан журмын дагуу үнэн зөв гаргаж, төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх;

14.1.12.гэрээт талбайд гүйцэтгэсэн үйл ажиллагааны анхдагч мэдээ материал болон үр дүнгийн мэдээлэл, өгөгдөл, тайлан, дээж, сорьц, түүний шинжилгээний үр дүн, батлагдсан зураг төслийг төрийн захиргааны байгууллагад цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүргүүлэх;

14.1.13.үйл ажиллагааны явцад түүх, соёлын олдвор, эд өлгийн зүйл илэрсэн тохиолдолд тухайн газарт явуулж байгаа ажлыг зогсоож, холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэх;

14.1.14.үйл ажиллагааны тайлан, хөрөнгө оруулалт, өмчлөлтэй холбоотой аливаа мэдээллийг Засгийн газрын хүсэлтээр тухай бүр гаргаж өгөх;

14.1.15.техникийн осол, саатал, санхүүгийн хүндрэл, шүүхийн болон улсын байцаагчийн шийдвэр, эсхүл иргэд, төрийн бус байгууллагын эсэргүүцэл зэрэг шалтгаанаар хайгуул, ордын хөгжүүлэлт, олборлолт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагааг зогсоох тохиолдолд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад нэн даруй мэдэгдэх;

14.1.16.гэрээлэгчийн нийт хувьцааны 50-аас дээш хувийн хувьцааг эзэмшиж байгаа этгээд өөрчлөгдсөн тохиолдолд энэ талаар төрийн захиргааны байгууллагад мэдэгдэх;

14.1.17.Энэ хуульд заасан гэрээний дагуу сургалтын урамшууллыг жил бүр төлөх.

15 дугаар зүйл.Хүний нөөцийн болон нийгмийн хариуцлагын үүрэг

15.1.Гэрээлэгч хүний нөөцийн удирдлага болон орон нутгийн харилцааны хүрээнд дараах үүргийг хүлээнэ:

15.1.1.үйл ажиллагаандаа дэвшилтэт технологи нэвтрүүлэх, Монгол Улсын иргэнийг инженер-техникийн болон мэргэжлийн ажлын байраар тэргүүн ээлжинд хангах, тэдгээрийг сургаж дадлагажуулах;

15.1.2.ижил төрлийн ажил хөдөлмөр эрхэлж байгаа гадаад, дотоодын ажилтны цалин хөлс, урамшууллыг ялгаварлалгүйгээр тэгш тогтоох, ажилтны хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах;

15.1.3.ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Хамтын ажиллагааны гурвалсан гэрээг төрийн захиргааны байгууллага болон тухайн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай байгуулж ажиллах;

15.1.4.байгаль орчин, нөхөн сэргээлт болон татан буулгалтын асуудлаар төрийн байгууллага болон орон нутгийн иргэдийг тогтмол мэдээллээр хангах үүрэг бүхий хариуцлагатай албан тушаалтныг томилж ажиллуулах.

16 дугаар зүйл.Дотоодын ханган нийлүүлэлтийг дэмжих

16.1.Гэрээлэгч, оператор болон туслан гүйцэтгэгч нь үйл ажиллагаандаа шаардагдах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгохдоо Монгол Улсад бүртгэлтэй, татвар төлөгч, дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид тэргүүн ээлжинд давуу эрх олгоно.

16.2.Монгол Улсын аж ахуйн нэгжийн чадавх, хүрэлцээ, тухайн үйл ажиллагаанд тавих техникийн шаардлагад нийцээгүйгээс шалтгаалан энэ хуулийн 16.1-д заасан үүргийг биелүүлэх боломжгүй болсон нь нотлогдсон тохиолдолд төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр уг үүргээс бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж болно.

17 дугаар зүйл.Оператор, туслан гүйцэтгэгчийн үүрэг

17.1.Оператор нь Компанийн тухай хуульд заасан эрх, үүргээс гадна энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-14.1.5, 14.1.9-14.1.15-д заасан гэрээлэгчийн нийтлэг үүрэг, 15 дугаар зүйлд заасан хүний нөөцийн болон нийгмийн хариуцлагын үүрэг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасан шаардлагыг адил хүлээж, үйл ажиллагааны хариуцлагыг гэрээлэгчийн хамт хүлээнэ.

17.2.Туслан гүйцэтгэгч хуулийн этгээд нь Компанийн тухай хуульд заасан эрх, үүргээс гадна энэ хуулийн 14.1.1, 14.1.5, 14.1.8, 14.1.13-т заасан гэрээлэгчийн нийтлэг үүрэг, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2-т заасан хүний нөөцийн үүрэг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасан шаардлагыг адил хүлээж, үйл ажиллагааны хариуцлагыг гэрээлэгчийн хамт хүлээнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ГЭРЭЭНИЙ ТӨРӨЛ, ГЭРЭЭГ ӨӨРЧЛӨХ, ЦУЦЛАХ НӨХЦӨЛ

18 дугаар зүйл.Гэрээний төрөл, шаардлага

18.1.Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд дараах гэрээг байгуулна:

18.1.1.Бүтээгдэхүүн хуваах гэрээ;

18.1.2.Татвар-нөөц ашигласны төлбөрийн гэрээ;

18.1.3.Орлого хуваах гэрээ;

18.1.4.Хамтарсан хөрөнгө оруулалтын гэрээ.

18.2.Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны бүх эрсдэл, хөрөнгө оруулалт, санхүүжилтийг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцах бөгөөд борлуулсан нийт газрын тос, уламжлалт бус газрын тосноос энэ хуульд заасан нөөц ашигласны төлбөр, өртөг нөхөх зардалд тооцох

өртөгт тос болон борлуулалтын зардлыг хассаны дараа үлдэх ашигт тосыг Засгийн газар болон гэрээлэгч гэрээнд заасан хувь хэмжээгээр хувааж өмчилнө.

18.3.Газрын тосны тухай хуульд заасан гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахад холбогдох татвар, төлбөртэй холбоотой харилцааг Монгол Улсын татварын хууль тогтоомж болон тухайн гэрээгээр зохицуулна.

18.4.Энэ зүйлийн 18.1.1-д заасан гэрээгээр гэрээлэгчийн хөрөнгө оруулалтыг нөхөхөд зориулсан тухайн жилд борлуулсан өртөгт тосны хэмжээ нь газрын тосны хувьд 60 хүртэл хувь, уламжлалт бус газрын тосны хувьд 90 хүртэл хувь байна.

18.5.Энэ хуулийн 14.1.8-д заасан зохицуулалт Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгчид хамаарна.

18.6.Татвар-нөөц ашигласны төлбөрийн гэрээгээр гэрээлэгч борлуулсан нийт газрын тос, уламжлалт бус газрын тосыг хүргэлтийн цэг дээр 100 хувь өөрийн өмчлөлд авч захиран зарцуулах эрхтэй байх бөгөөд хуульд заасан нөөц ашигласны төлбөр болон Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу холбогдох аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, бусад татвар, хураамжийг төсөвт бүрэн төлнө.

18.7.Газрын тосны төрийн өмчит компани болон хөрөнгө оруулагч хамтран хөрөнгө оруулалт хийж, эрсдэлээ хуваах зорилгоор Хамтарсан хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж болно.

18.8.Хамтарсан хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахдаа төрийн өмчийн оролцооны хувь хэмжээг төслийн эдийн засгийн үр ашиг, геологийн эрсдэлийг харгалзан гэрээгээр тохиролцоно. Төрийн өмчийн оролцоотой холбоотой шийдвэр нь хөрөнгө оруулагчийн бизнесийн удирдлагын бие даасан байдалд хөндлөнгөөс оролцох үндэслэл болохгүй.

18.9.Гэрээлэгчийн гаргасан зардлыг хасахгүйгээр, борлуулалтын орлогыг шууд хуваарилах нөхцөлтэй Орлого хуваах гэрээг төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр байгуулж болно.

18.10.Орлого хуваах гэрээгээр гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны бүх эрсдэл, хөрөнгө оруулалт, санхүүжилтийг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцах бөгөөд борлуулсан нийт газрын тос, уламжлалт бус газрын тосны борлуулалтын орлогыг гэрээнд заасан хувь хэмжээгээр Засгийн газартай хуваана.

19 дүгээр зүйл. Гэрээний төрлийг өөрчлөх

19.1.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулагдсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч хайгуулын ажлыг дэмжих, ордын хөгжүүлэлт, олборлолтыг нэмэгдүүлэх, нөөцийг өсгөх, эсхүл зардлын маргааныг шийдвэрлэх зорилгоор талууд харилцан зөвшилцөж, гэрээний төрлийг энэ хуулийн 18.1-д заасан гэрээний аль нэг хэлбэрт шилжүүлэн өөрчлөх хүсэлтийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж болно.

19.2.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 19.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянаж, дүгнэлтээ газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

19.3.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 19.2-т заасан дүгнэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гэрээний

төрлийг өөрчлөх эсэхийг шийдвэрлэнэ. Гэрээний төрлийг өөрчлөхөөс татгалзсан бол үндэслэлийг гэрээлэгчид бичгээр мэдэгдэнэ.

19.4.Гэрээний төрлийг өөрчлөх шийдвэр гарснаас хойш талууд 90 хоногийн дотор шинэ гэрээний нөхцөлийг харилцан тохиролцож, гэрээнд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулна. Өөрчлөн байгуулсан гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл өмнөх гэрээний эрх, үүргийн үйлчлэл хэвээр үргэлжилнэ.

20 дугаар зүйл.Гэрээ цуцлах, дуусгавар болох үндэслэл

20.1.Газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах гэрээг доор дурдсан үндэслэлээр төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр цуцална:

20.1.1.хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд ноцтой хохирол учруулсан, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ хэрэгжүүлээгүй нь эрх бүхий төрийн байгууллагаар тогтоогдсон;

20.1.2.сонгон шалгаруулалтын баримт бичиг болон хэлэлцээ хийх явцад ирүүлсэн баримт бичиг хууль бус болохыг эрх бүхий байгууллага гэрээ батлагдсанаас хойш тогтоосон;

20.1.3.газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар худал мэдээлэл, тайлан өгснөөс төрд үлэмж хэмжээний хохирол учирсан нь тогтоогдсон;

20.1.4.хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулах эрх, үүргээ гэрээлэгч хууль бусаар шилжүүлсэн, эсхүл эрх, үүрэг шилжүүлсний төлбөрийг хуульд заасан хугацаанд төлөөгүй;

20.1.5.гэрээлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

20.1.6.гэрээлэгчийн тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан бөгөөд уг зөвшөөрлийг сунгах хүсэлтийг хуульд заасан хугацаанд гаргаагүй.

20.2.Гэрээлэгч дараах үндэслэлээр гэрээ цуцлах хүсэлтийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж болно:

20.2.1.энэ хуулийн 35.1-д заасан онц байдал, давагдашгүй хүчин зүйл болон гэрээлэгчээс үл хамаарах бусад нөхцөл байдлын улмаас газрын тосны үйл ажиллагааг хоёр ба түүнээс дээш жил дараалан үргэлжлүүлэх боломжгүй болсон;

20.2.2.гуравдагч этгээдийн хууль бус үйл ажиллагаа, орон нутгийн иргэдийн эсэргүүцэл, гэрээлэгчийн эрх зүйн байдлыг дордуулсан захиргааны хэм хэмжээний акт, төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй, эсхүл хууль бусаар татвар, нөхөн татвар, торгууль ногдуулсны улмаас үйл ажиллагаагаа хууль ёсоор хэрэгжүүлэх боломжгүй болж, уг нөхцөл байдал хоёр ба түүнээс дээш жил үргэлжилсэн;

20.2.3.арилжааны ач холбогдол бүхий нээлт тогтоогдоогүй, хайгуулын үр дүн хангалтгүй гарсан, зах зээлийн нөхцөл байдал ноцтой дордсон, эсхүл үйл ажиллагааг үргэлжлүүлэх нь техникийн болон эдийн засгийн хувьд үр ашиггүй болсон;

20.2.4.гэрээлэгч төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаанд орсон, дампуурсан, эсхүл татан буугдсан.

20.3.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.2-т заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянаж, дүгнэлтээ газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

20.4.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 20.3-т заасан дүгнэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянаж, гэрээг цуцлах эсэхийг эцэслэн шийдвэрлэнэ.

20.5. Энэ хуулийн 20.2-т заасан үндэслэлээр гэрээ цуцлагдсан тохиолдолд гэрээлэгчийн хууль ёсоор олж авсан эрх, баталгаажсан өртөг нөхөх зардлын үлдэгдэл болон бусад төлбөр тооцоог энэ хууль болон гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ.

20.6.Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүйн улмаас гэрээ цуцлагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол гэрээлэгчид учруулсан бодит хохирлыг Иргэний хууль болон Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу барагдуулна. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр баталгаажсан өртөг нөхөх зардлын үлдэгдлийг гэрээлэгчийн байгуулсан бусад бүтээгдэхүүн хуваах гэрээнд шилжүүлэн тооцож болно.

20.7.Энэ хуулийн 20.1-д заасан үндэслэлээр гэрээг цуцалсан тохиолдолд хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг төрөөс нөхөн олгохгүй бөгөөд татан буулгалтын үйл ажиллагаанд зориулж Монгол Улсын арилжааны банкны хадгаламжийн дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг татан буулгалтын үйл ажиллагаанд зарцуулж, үлдсэн хэсгийг гэрээлэгчид буцаан олгоно.

21 дүгээр зүйл.Гэрээний эрх, үүргийг бусдад шилжүүлэх

21.1.Гэрээлэгч энэ хуульд заасан гэрээний дагуу хүлээсэн эрх, үүргээ бусдад бүхэлд нь, эсхүл дийлэнхийг шилжүүлэх тохиолдолд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг авна.

21.2.Гэрээлэгч гэрээний эрх, үүргийг шилжүүлэх хүсэлтийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд уг байгууллагын дүгнэлтийг үндэслэн газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэр гаргана.

21.3.Гэрээний эрх, үүргийг шилжүүлэх үйл ажиллагааны дараалал, хугацааг дараах байдлаар тогтооно:

21.3.1.газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэрээлэгчийн хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дүгнэлт гаргаж, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

21.3.2.газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлтийг хянан үзээд 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

21.4.Гэрээний эрх, үүргийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлэх газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсан тохиолдолд шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, гэрээлэгч болон эрх, үүргийг шилжүүлэн авч байгаа этгээдийн хооронд гурван талт гэрээ байгуулна.

21.5.Гэрээлэгч болон гэрээний эрх, үүргийг шилжүүлэн авч байгаа этгээд эрх шилжүүлэх хэлцлийн бодит үнэ, төлсөн төлбөрийн хэмжээг хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тайлагнах, шударгаар мэдээлэх үүрэгтэй.

21.6.Гэрээлэгч гэрээний эрх, үүргийг шилжүүлэх газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор энэ хуульд заасан эрх шилжүүлсний төлбөр болон холбогдох татварыг улсын төсөвт бүрэн төлнө.

21.7.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрх, үүрэг шилжүүлэх дүгнэлт гаргахдаа гэрээлэгч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ бүрэн биелүүлсэн эсэх талаарх байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох орон нутгийн Засаг даргын тодорхойлолтыг харгалзан үзнэ.

21.8.Гэрээлэгч нь гэрээний эрх, үүргийг өөрийн хараат болон охин компанид шилжүүлэх тохиолдолд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, бүртгүүлнэ. Энэхүү бүртгэл нь татвар ногдуулах, эрх шилжүүлэх үндсэн зохицуулалтад хамаарахгүй бөгөөд зөвхөн мэдээллийн шинжтэй байна.

21.9.Гэрээлэгч гэрээний эрх, үүргээ шилжүүлэхдээ хайгуулын талбайд нээлт тогтоогдохоос өмнө 20000 америк доллар, нээлт тогтоогдсоны дараа 50000 америк доллартай тэнцэх хэмжээний төгрөгийг улсын төсөвт төлнө.

21.10.Ашиглалтын үед гэрээний эрх, үүргээ шилжүүлбэл 100000 америк доллартай тэнцэх хэмжээний төгрөгийг улсын төсөвт төлнө.

22 дугаар зүйл.Гэрээний биелэлтийг дүгнэх

22.1.Энэ хуульд заасан гэрээний хугацаа дуусгавар болсон, эсхүл гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тохиолдолд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэрээний биелэлтийг дараах үзүүлэлтээр дүгнэнэ:

22.1.1.гэрээлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн байдал;

22.1.2.гэрээлэгч байгаль орчны нөхөн сэргээлтийг стандартын дагуу бүрэн хийж дуусгасан эсэх;

22.1.3.гэрээлэгч хууль тогтоомжийн дагуу төлөх ёстой татвар, төлбөр, хураамжийг бүрэн төлж барагдуулсан эсэх;

22.1.4.гэрээлэгч эд хөрөнгийн өмчлөл болон татан буулгалтын асуудлыг шийдвэрлэсэн эсэх;

22.1.5.геологи, геофизикийн анхдагч болон боловсруулсан тайлан, өгөгдөл, дээж, сорьцыг төрийн захиргааны байгууллагад бүрэн хүлээлгэн өгсөн эсэх;

22.2.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэрээний биелэлтийг дүгнэхдээ байгаль орчин, татвар, хяналт шалгалтын болон холбогдох төрийн байгууллагын төлөөллийг оролцуулна.

22.3.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэрээний биелэлтийг “бүрэн хангасан” гэж дүгнэсэн тохиолдолд гэрээлэгчийн байршуулсан татан буулгалтын зардлын баталгаа, барьцаа хөрөнгийг чөлөөлөх бөгөөд энэ нь тухайн талбайд тусгай зөвшөөрөл дахин олгоход давуу эрх эдлэх үндэслэл болно.

22.4 Энэ хуулийн 20.2-т заасны дагуу гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тохиолдолд гэрээний биелэлтийг дүгнэхдээ гэрээлэгчийн хүсэлт гаргасан өдрийг

хүртэл үүссэн тусгай зөвшөөрлийн төлбөр, гэрээний урамшуулал, татварыг бүрэн төлүүлж, энэ хуулийн 14.1.5-д заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, татан буулгах ажил болон геологийн анхдагч ба үр дүнгийн тайлан, өгөгдөл, дээж, сорьцыг төрд бүрэн хүлээлгэн өгөх үүргийг хариуцуулна.

22.5.Энэ хуулийн 22.4-т заасан үүргийн биелэлтийг “бүрэн хангасан” гэж дүгнэн гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан өдрөөс хойшхи үлдсэн хайгуулын жилүүдэд хамаарах хайгуулын ажлын доод хэмжээний үүрэг, тусгай зөвшөөрлийн төлбөр, урамшуулал болон ирээдүйд үүсэх бусад гэрээний үүргээс гэрээлэгчийг бүрэн чөлөөлнө.

ТАВДУГААР БҮЛЭГ

УЛАМЖЛАЛТ БУС ГАЗРЫН ТОС

23 дугаар зүйл.Уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд тавих тусгай шаардлага

23.1.Уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд олон улсын дэвшилтэт техник, технологи, арга, аргачлал, стандарт, дүрэм журмыг мөрдөнө.

23.2.Уламжлалт бус газрын тосны олборлолтын үйл ажиллагааны явцад шавхалтаар олборлосон формацын усыг зориулалтын санд хадгалж, задгайгаар ууршуулах, үйлдвэрлэлийн зориулалтаар дахин ашиглах, эсхүл хураагуурын даралтыг дэмжих зорилгоор буцаан хураагуурт шахаж болно.

24 дүгээр зүйл.Уламжлалт бус газрын тосны татвар, санхүү, гэрээний урамшуулал олгох

24.1.Уламжлалт бус газрын тосны хайгуул, үнэлгээний ажлын онцлогийг харгалзан хайгуулын тусгай зөвшөөрлийг 10 хүртэл жилийн хугацаагаар олгох бөгөөд хугацааг 5 хүртэл жилээр 1 удаа сунгаж болно.

24.2.Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй нөхцөлд тухайн жилд нөхөгдөх өртөгт тосны дээд хязгаарыг гэрээлэгч болон Засгийн газар гэрээгээр харилцан тохиролцож тогтооно.

24.3.Гэрээлэгч нь газрын тосны гэрээт талбайд уламжлалт бус газрын тосны орд шинээр тогтоогдсон тохиолдолд тусад нь гэрээ байгуулж, хөрөнгө оруулалт, зардлын бүртгэлийг тус тусад нь хөтөлнө.

24.4.Уламжлалт бус газрын тосны төслийн техникийн онцлог, хэрэглэгч болон дамжуулах дэд бүтцийн бэлэн байдлыг харгалзан тухайн төслийн эрэл, хайгуул, үнэлгээ, ашиглалттай холбогдсон үйл ажиллагаа, тэдгээрийн ажлын хөтөлбөрийг төслийн техникийн онцлогт нийцүүлэн уян хатан тогтоох харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна.

25 дугаар зүйл.Уламжлалт бус газрын тосны эрэл

25.1.Улсын тусгай хамгаалалттай газраас бусад улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газарт уламжлалт бус газрын тосны эрэл хийж болно.

25.2.Уламжлалт бус газрын тосны эрлийн ажлыг хуулийн этгээд төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгэнэ.

25.3.Нэг хуулийн этгээдэд олгох уламжлалт бус газрын тосны эрлийн талбайн хэмжээг газрын тосны сав газрын геологийн тогтцыг харгалзан төрийн захиргааны байгууллага тогтооно.

25.4.Хуулийн этгээд уламжлалт бус газрын тосны эрэл хийх хүсэлтээ төрийн захиргааны байгууллагад гаргана.

25.5.Энэ хуулийн 25.4-т заасан хүсэлтэд дараах зүйлийг тусгана:

25.5.1.эрэл хийх талбайн байршил, хэмжээ;

25.5.2.эрлийн хугацаанд хийх ажлын ерөнхий хөтөлбөр;

25.5.3.техникийн хүчин чадал, хүний нөөцийн чадавх;

25.5.4.төлөвлөсөн ажлыг санхүүжүүлэх санхүүгийн боломж, эх үүсвэр;

25.5.5.тухайн жилд гүйцэтгэх эрлийн ажлын төлөвлөгөө, төсөл.

25.6.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 25.1-д заасан эрэл хийх хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн хугацаанд судалж, шийдвэр гаргана.

25.7.Тухайн талбайд эрэл хийх хүсэлтийг хоёр ба түүнээс дээш хуулийн этгээд гаргасан тохиолдолд төрийн захиргааны байгууллага харьцуулсан дүгнэлт хийж, шийдвэр гаргана.

25.8.Төрийн захиргааны байгууллага эрэл хийх шийдвэр гаргахдаа дараах нөхцөлийг харгалзана:

25.8.1.хүсэлт гаргагч нь техник, технологи, мэргэжлийн болон санхүүгийн чадавхтай эсэх;

25.8.2.эрлийн ажлын арга, аргачлал нь олон улсын жишигт нийцсэн эсэх;

25.8.3.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө.

25.9.Энэ хуулийн 25.6, 25.7-д заасан шийдвэрийг үндэслэн уламжлалт бус газрын тос эрэх гэрээг 2 хүртэл жилийн хугацаагаар байгуулна.

25.10.Эрлийн гэрээний эрх, үүргийг өөр этгээдийн нэр дээр шилжүүлэхийг хориглоно.

25.11.Уламжлалт бус газрын тосны эрэл хийсэн этгээд нь эрлийн ажлын анхдагч материал, үр дүнгийн тайлан мэдээг төрийн захиргааны байгууллагад өгч дүгнэлт гаргуулах үүрэгтэй.

25.12.Уламжлалт бус газрын тосны эрлийн үед өрөмдлөг хийж болно.

25.13.Эрэл хийсэн этгээд нь эрлийн ажлын үр дүнгийн тайланд төрийн захиргааны байгууллагаар дүгнэлт гаргуулснаас хойш 60 хоногийн хугацаанд уламжлалт бус газрын тосны эрлийн талбайд хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах талаар гэрээ байгуулах саналаа ирүүлнэ.

25.14.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 25.13-т заасан саналыг хүлээн авч, эрэл хийсэн этгээдтэй хайгуул, ашиглалтын гэрээний төслийн талаар 60

хоногийн дотор хэлэлцээ хийж, эцэслэн тохиролцсон төслийг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

25.15.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 25.14-т заасан гэрээний төслийг 30 хоногийн дотор хянаж үзээд гэрээ байгуулах эсэх талаар шийдвэр гаргана.

25.16.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 30 хоногийн дотор эрэл хийсэн этгээдтэй гэрээ байгуулж, энэ талаар нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

25.17.Энэ хуулийн 25.14-т заасан хэлэлцээ хийх явцад талууд тохиролцоонд хүрч чадаагүй бол газрын тосны эрлийн талбайг хайгуулын талбайгаар зарлана.

26 дугаар зүйл. Уламжлалт бус газрын тосны хайгуул, үнэлгээний хөтөлбөр

26.1.Гэрээлэгч нь уламжлалт бус газрын тосны үнэлгээний хөтөлбөрийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар батлуулж хэрэгжүүлнэ.

26.2.Гэрээлэгч нь хайгуулын ажлын явцын үр дүнгээс хамааран үнэлгээний хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй.

26.3.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 26.1, 26.2-д заасан хөтөлбөр, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан үзэж шийдвэр гаргана. Хэрэв энэ хугацаанд хариу өгөөгүй бол хөтөлбөрийг зөвшөөрсөнд тооцно.

26.4.Энэ хуулийн 30.10-т заасан цооногийн олборлолтыг зогсоох зохицуулалт нь уламжлалт бус газрын тосны олборлолтын үйл ажиллагаанд үйлчлэхгүй.

27 дугаар зүйл. Нүүрсний давхаргын метан хий олборлолт

27.1.Нүүрсний тусгай зөвшөөрөл бүхий талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуул, ашиглалт явуулах тохиолдолд талууд хөдөлмөрийн аюулгүй байдал, үйл ажиллагааны дарааллыг харилцан тохиролцож энэ хуульд заасан талбай хамтран ашиглах гэрээг байгуулна.

27.2.Нүүрсний давхаргын метан хийн хайгуул, үнэлгээний үйл ажиллагааны явцад хийх формацын усны шавхалт нь олборлолтын туршилт, туршилтын олборлолтын салшгүй хэсэг бөгөөд шавхалтаар олборлосон усыг зориулалтын санд хадгалж, ууршуулах, үйлдвэрлэлийн зориулалтаар дахин ашиглах, эсхүл хураагуурын даралтыг дэмжих зорилгоор буцааж шахаж болно. Олборлолтын туршилт, туршилтын олборлолтоор олборлосон метан хийг гэрээнд заасны дагуу борлуулж болно.

27.3.Нүүрсний давхаргын метан хийн олборлолтын туршилт, туршилтын олборлолтын үед олборлосон нүүрсний давхаргын метан хийг гэрээлэгч өөрийн үйл ажиллагааны хэрэгцээнд үнэ төлбөргүй ашиглаж болно.

27.4.Олборлолтын туршилт, туршилтын олборлолт, цооногийн туршилтын үед аюулгүй ажиллагаа, даралт бууруулах, тоног төхөөрөмж хамгаалах, уурхайн болон талбайн эрсдэлийг бууруулах зорилгоор метан хийг батлагдсан аюулгүй ажиллагаа, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хяналттайгаар бамбардан шатааж болно.

27.5.Нүүрсний давхаргын метан хийн хайгуул, үнэлгээний явцад хийх олборлолтын туршилт, туршилтын олборлолтын хугацааг энэ хуулийн 31.6-д заасан уламжлалт бус газрын тосны олборлолтын туршилтын онцлог зохицуулалтын дагуу гүйцэтгэнэ.

27.6.Ашигт малтмалын тухай хуульд заасан нүүрсний тусгай зөвшөөрөл нь нүүрсний давхаргын метан хийн хайгуул, ашиглалт, борлуулалтын эрхийг агуулахгүй.

27.7.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нүүрсний уурхайн аюулгүй ажиллагааг хангах, агааржуулалт, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор нүүрсний уурхайн метан хийг зайлуулах, цуглуулах, ашиглах эрхтэй.

27.8.Энэ зүйлийн 27.7-д заасан эрх нь нүүрсний давхаргын метан хийн туршилтын олборлолт, олборлолтын туршилт, нөөц тооцоолох, бүртгүүлэх борлуулах, эсхүл түүнийг арилжааны зорилгоор олборлох эрхийг үүсгэхгүй.

27.9.Нүүрсний давхаргын метан хийг арилжааны зорилгоор хайх, ашиглах, олборлох, борлуулах үйл ажиллагаа нь энэ хуульд заасан газрын тос, уламжлалт бус газрын тосны гэрээ, тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжинэ.

28 дугаар зүйл.Талбайн хэмжээ, ашиглалтын хугацаа, бусад ашигт малтмалын давхцалыг зохицуулах

28.1.Уламжлалт бус газрын тосны ордын хөгжүүлэлт, дэд бүтэц барьж байгуулах хугацааг харгалзан ашиглалтын хугацааг 30 хүртэл жилийн хугацаагаар олгож, хугацааг 5 хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно. Батлагдсан орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ордыг хөгжүүлэх, шаардлагатай дэд бүтэц барьж байгуулахад зарцуулсан хугацааг ашиглалтын хугацаанд нэмж тооцно.

28.2.Газрын тос, уламжлалт бус газрын тосны гэрээт талбайд Ашигт малтмалын тухай хуулийн дагуу олгогдсон хатуу ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн давхацсан тохиолдолд талууд үйл ажиллагааны дараалал, хугацааны график, хөдөлмөрийн аюулгүй байдлыг харилцан уялдуулж талбай хамтран ашиглах гэрээг байгуулна.

28.3.Газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны явцад гэрээт талбайгаас бусад төрлийн ашигт малтмалын шинэ илрэл, орд тогтоогдсон тохиолдолд гэрээлэгч уг ашигт малтмалыг тусгай зөвшөөрөлгүйгээр олборлох, ашиглахыг хориглоно. Гэрээлэгч энэ талаар газрын тосны болон геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 30 хоногийн дотор мэдэгдэж, холбогдох мэдээлэл, материалыг бүртгүүлнэ.

28.4.Энэ хуулийн 28.3-т заасан илрэл, орд нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөлгүй талбайд байгаа бол түүнийг илрүүлж, бүртгүүлсэн гэрээлэгчид Ашигт малтмалын тухай хуульд заасан шаардлагыг хангасан нөхцөлд тухайн талбайн хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэх тэргүүн ээлжийн эрх олгоно.

28.5.Тухайн талбайн тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох бол илрэлийг бүртгүүлсэн гэрээлэгч сонгон шалгаруулалтын ялагчийн саналыг ижил нөхцөлөөр хэрэгжүүлэх давуу эрхтэй байна. Гэрээлэгч энэ эрхээ хэрэгжүүлээгүй бол шинэ илрэл, ордыг тогтооход зарцуулсан эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан шууд зардлыг тусгай зөвшөөрөл авсан этгээд гэрээлэгчид нөхөн төлнө.

28.6.Талбай хамтран ашиглах гэрээ байгуулах явцад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон метан хийн гэрээлэгч талууд үйл ажиллагааны график,

технологийн дарааллыг тохиролцож чадаагүй маргаан гарвал нүүрсний давхаргын метан хийн ашиглалтын үйл ажиллагааг тэргүүн ээлжид явуулна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ХАЙГУУЛ, АШИГЛАЛТ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

29 дүгээр зүйл. Газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах талбайд гэрээлэгч сонгон шалгаруулах

29.1. Төрийн захиргааны байгууллага доор дурдсан хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлана:

29.1.1. улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн болон төрийн захиргааны байгууллагаас ялгасан талбай;

29.1.2. өмнөх хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуул хийхээс татгалзаж талбайгаа буцааж өгсөн, эсхүл удаа дараа зөрчил гаргаснаас эрх бүхий этгээд тусгай зөвшөөрөл болон гэрээг хүчингүй болгосон;

29.1.3. хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж талбайг буцаан авсан;

29.1.4. энэ хуульд зааснаар гэрээ нь цуцлагдсан, эсхүл энэ хуулийн 13.1.6-д заасан нөхцөл байдал үүссэн;

29.1.5. хуульд заасан бусад.

29.2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын талбай, түүний хэмжээг сав газрын үүсэл, хөгжил, геологийн тогтцыг харгалзан газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ялгаж тогтооно.

29.3. Төрийн захиргааны байгууллагаас ялгасан хайгуулын талбайд газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагчийг нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмаар сонгоно.

29.4. Энэ хуулийн 29.3-т заасан нээлттэй сонгон шалгаруулалт явуулах журмыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

29.5. Сонгон шалгаруулалтад шалгарсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээний хугацааг сунгах шийдвэрийг төрийн захиргааны байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

29.6. Энэ хуулийн 29.4-т заасан журмаар сонгон шалгаруулалтын урилгыг нийтэд зарлах хугацаа, хөрөнгө оруулагчийн техникийн болон санхүүгийн чадавхийг үнэлэх үйл ажиллагааг зохицуулна.

29.7. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын дагуу үнэлгээ хийж, Засгийн газарт хамгийн ашигтай санал ирүүлсэн оролцогчийг шалгаруулан энэ тухай сонгон шалгаруулалтад оролцогчдод мэдээлнэ.

29.8. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 29.7-д заасан шалгарсан оролцогчтой 60 хоногийн дотор хайгуул, ашиглалтын гэрээний төслийн талаар хэлэлцээ хийж эцэслэн тохиролцсон төслийг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

29.9.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 29.8-д заасан гэрээний төслийг 30 хоногийн дотор хянаж үзээд гэрээ байгуулах эсэх талаар шийдвэр гаргана.

29.10.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 30 хоногийн дотор гэрээ байгуулж, энэ талаар нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

29.11.Энэ хуулийн 29.8-д заасан хэлэлцээ хийх явцад талууд тохиролцоонд хүрч чадаагүй бол хайгуулын талбайд сонгон шалгаруулалтын үнэлгээний дараагийн ашигтай санал ирүүлсэн оролцогчтой хэлэлцээ хийнэ.

29.12.Нэг талбайд газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах тохиолдолд гэрээлэгч нь нэг байж болох бөгөөд төрөл тус бүрээр нь гэрээ байгуулж, тусгай зөвшөөрөл авна.

29.13.Төрийн захиргааны байгууллага дараах тохиолдолд ашиглалтын талбайд нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлана:

29.13.1.газрын тос, уламжлалт бус газрын тосны нөөцийг хүлээн авсан тухай төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсны дараа хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргаагүй;

29.13.2.улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж, нөөцийг тогтоосон;

29.13.3.өмнөх ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын үйл ажиллагаа явуулахаас татгалзаж талбайг буцааж өгсөн, эсхүл удаа дараа зөрчил гаргаснаас эрх бүхий этгээд тусгай зөвшөөрөл болон гэрээг хүчингүй болгосон;

29.13.4.ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж талбайг буцааж авсан.

29.14.Энэ хуулийн 29.13-т заасан талбайд энэ хуульд заасан журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, гэрээлэгчийг сонгон шалгаруулна.

29.15.Энэ хуулийн 29.4-д заасан нээлттэй сонгон шалгаруулалт явуулах журмаар ялгасан талбайд урилга нийтэд зарлах хугацааны хязгаар, хөрөнгө оруулагчийн техникийн болон санхүүгийн чадавхыг үнэлэх шалгуур үзүүлэлт болон ашигтай санал ирүүлсэн оролцогчийг эрэмбэлэн тодруулах үнэлгээний агуулга, хүрээг нарийвчлан тогтооно.

30 дугаар зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох, сунгах

30.1.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 29.10-д заасны дагуу байгуулагдсан гэрээг үндэслэн олгоно.

30.2.Гэрээлэгч нь хайгуулын тусгай зөвшөөрөл авах тухай хүсэлтийг гэрээ байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

30.3.Хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

30.3.1.энэ хуулийн 29.10-д заасан гэрээний хуулбар;

30.3.2.хайгуулын эхний жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл.

30.4.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 30.3.1, 30.3.2-т заасан баримт бичгийг хянан үзэж, хайгуулын тусгай зөвшөөрлийг хайгуулын хугацаагаар гэрээлэгчид олгож, сунгана.

30.5.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 30.2, 30.11-д заасан гэрээлэгчийн хүсэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг олгох, сунгах эсэх тухай шийдвэрийг гаргаж, гэрээлэгчид хариу мэдэгдэнэ.

30.6.Тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу бүртгэж, цахим хэлбэрээр олгох бөгөөд тусгай зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

30.7.Газрын тосны хайгуулын хугацаа 8 хүртэл жил байх бөгөөд уг хугацааг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 2 хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно.

30.8.Уламжлалт бус газрын тосны хайгуулын хугацаа 10 хүртэл жил байх бөгөөд уг хугацааг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 5 хүртэл жилээр нэг удаа сунгаж болно.

30.9.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс хайгуулын хугацааг тооцно.

30.10.Хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийн хугацааг бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан гэрээний жилээр буюу дараалсан 12 сарын хугацаагаар тооцно. Төрийн захиргааны байгууллагын шийдвэрээс шалтгаалан төлөвлөгөө, төсөв хугацаа хоцорч батлагдсан бол хоцорсон хугацаагаар тухайн төлөвлөгөө, төсвийг хэрэгжүүлэх хугацааг сунгана.

30.11.Гэрээлэгч хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийн төслийг дараах хугацаанд төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ:

30.11.1.Эхний жилийн хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг тусгай зөвшөөрөл олгосноос хойш 60 хоногийн дотор;

30.11.2.Дараагийн жилүүдийн хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг тухайн жилийн эхний улиралд багтаан.

30.12.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 30.11-т заасан төлөвлөгөө, төсвийн төслийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан үзэж батална.

30.13.Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тохиолдолд гэрээлэгч доор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, төрийн захиргааны байгууллагаар дамжуулан төрийн захиргааны төв байгууллагад хугацаа сунгах хүсэлтээ ирүүлнэ:

30.13.1.хайгуулын хугацаанд гүйцэтгэсэн ажлын нэгдсэн тайлан;

30.13.2.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын тайлан;

30.13.3.сунгасан хугацаанд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл.

30.14.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 30.13-д заасан баримт бичгийг хянаж хугацааг сунгах үндэслэлтэй гэж үзвэл энэ хуульд заасан хугацаагаар сунгаж, төрийн захиргааны байгууллага болон хүсэлт гаргасан гэрээлэгчид ажлын 5 хоногт мэдэгдэнэ.

30.15.Төрийн захиргааны байгууллага нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаарх мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

30.16.Гэрээлэгч нь хайгуулын ажлын хуримтлагдсан доод хэмжээг гүйцэтгэх үүргээ онц байдал, давагдашгүй хүчин зүйл, орон нутгийн иргэдийн эсэргүүцэл, эсхүл төрийн эрх бүхий байгууллагын болон албан тушаалтны хууль бус шийдвэр, эс үйлдэхүйн улмаас биелүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэнээс бусад үндэслэлээр хоёр буюу түүнээс дээш удаа биелүүлээгүй, хайгуулын үйл ажиллагааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 жил дараалан хийж гүйцэтгээгүй тохиолдолд хайгуулын хугацааг сунгахгүй.

30.17.Хайгуулын ажлын доод хэмжээний биелэлтийг бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хайгуулын хугацааны нийт дүнгээр хуримтлуулан тооцно. Хайгуулын ажилд бодитоор зарцуулсан зардлыг өртөг нөхөгдөх баталгаажсан зардалд хамааруулсан эсэхээс үл хамааран хайгуулын ажлын доод хэмжээний биелэлтэд тооцно. Тухайн жилд хүлээсэн доод хэмжээнээс илүү зарцуулсан хайгуулын зардлыг дараагийн жилийн хайгуулын ажлын доод хэмжээний биелэлтэд шилжүүлэн хуримтлуулж тооцно.

30.18.Тухайн жилийн хайгуулын ажлын доод хэмжээнээс илүү, эсхүл дутуу гүйцэтгэсэн дүнг дараагийн жилүүдэд шилжүүлэн, хайгуулын хугацааны нийт дүнд хуримтлуулан тооцно. Жилийн доод хэмжээ нь хайгуулын хугацааны нийт доод хэмжээг хуваарилсан төлөвлөлтийн үзүүлэлт байх бөгөөд тухайн жилийн дутуу гүйцэтгэл нь дангаараа үүргийн зөрчилд тооцогдохгүй. Хайгуулын ажлын доод хэмжээний эцсийн биелэлтийг хайгуулын хугацаа дуусахад хуримтлагдсан нийт дүнгээр тогтооно.

30.19.Хайгуулын ажлын жилийн тайлангаар батлагдсан гүйцэтгэл нь тухайн жилийн ажлын доод хэмжээнээс дутуу гарсан тохиолдолд гэрээлэгч нь уг дутуу гүйцэтгэлийн дүнтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр Монгол Улсын арилжааны банкны баталгааг гаргуулж, жилийн тайлан батлагдсанаас хойш 30 хоногийн дотор газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад байршуулах үүрэгтэй бөгөөд гэрээ цуцлагдсан, эсхүл талбай буцаагдсан тохиолдолд уг баталгааг ашиглаж дутуу гүйцэтгэлийн санхүүжилтийг улсын төсөвт төвлөрүүлнэ.

31 дүгээр зүйл.Нээлт, үнэлгээ, олборлолтын туршилт, туршилтын олборлолт

31.1.Гэрээлэгч хайгуулын цооногоос газрын тос илэрснээс хойш 15 хоногийн дотор энэ тухай төрийн захиргааны байгууллагад албан ёсоор мэдэгдэж, цооногийг бүртгүүлнэ.

31.2.Гэрээлэгч газрын тос илэрсэн цооногт туршилт судалгааны ажлыг хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд цооногийг бүртгүүлсэн өдрөөс хойш 360 хоногийн дотор уг цооногт туршилт, судалгааны ажлыг гүйцэтгэн нээлтийн цооног мөн эсэхийг тодорхойлж, төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.

31.3.Газрын тосны нээлтийн цооног бүртгэгдсэн тохиолдолд 180 хоногийн дотор үнэлгээний хөтөлбөрийг төрийн захиргааны байгууллагаар батлуулна.

31.4.Гэрээлэгч үнэлгээний хөтөлбөрөөр үр ашигтай нээлт мөн эсэхийг тогтоож, нөөцийн үнэлгээг тусгасан үнэлгээний ажлын тайланг үнэлгээний ажил дууссанаас хойш 180 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

31.5.Уламжлалт бус газрын тосны хувьд энэ зүйлийн 31.2, 31.3, 31.4-т заасан хугацаа хамаарахгүй.

31.6.Цооногийн олборлолтын туршилтын хугацаа нь газрын тосны хувьд 360 хүртэлх хоног байх ба уламжлалт бус газрын тосны хувьд олборлолтын туршилт, туршилтын олборлолтыг хугацаагаар хязгаарлахгүй бөгөөд олборлолтын туршилт, туршилтын олборлолтын явцад олборлосон газрын тос, уламжлалт бус газрын тосны тоо хэмжээ, чанарт газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтмол бүртгэл хөтөлж, хяналт тавина.

31.7.Онц байдал, давагдашгүй хүчин зүйл, орон нутгийн иргэдийн эсэргүүцэл, эсхүл нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаа, эс үйлдэхүйн улмаас гэрээлэгчийн хайгуул, бүтээн байгуулалт, олборлолтын туршилтын үйл ажиллагаа саатсан тохиолдолд гэрээлэгч энэ талаар газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 7 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

31.8.Энэ хуулийн 31.7-д заасан нөхцөл байдал үргэлжилсэн хугацаагаар энэ хуулийн 24.1, 28.1, 30.7, 30.8-д заасан хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, энэ хуульд заасан гэрээний дагуу төлөх төлбөр, урамшууллыг тусгай зөвшөөрлийн сунгасан хугацаагаар хойшлуулах бөгөөд саатсан хугацаанд төлбөр, урамшууллын болон гэрээлэгчийн хүлээх гэрээний бусад үүргийг царцаана.

31.9.Олборлолтын туршилт, туршилтын олборлолтын үед олборлосон газрын тос, уламжлалт бус газрын тосыг худалдаж, экспортолж болох бөгөөд нарийвчилсан харилцааг борлуулалтын гэрээгээр зохицуулна.

31.10.Олборлолтын туршилтын хугацаа дууссанаас хойш ашиглалт эхэлтэл тухайн цооногийн олборлолтыг зогсооно.

32 дугаар зүйл.Баялаг, нөөц

32.1.Гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцоог Газрын тосны баялгийн менежментийн системийн дагуу гүйцэтгэж, тайланг газрын тос, уламжлалт бус газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайлан боловсруулах аргачлалын дагуу боловсруулна.

32.2.Гэрээлэгч баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг хайгуулын хугацаа дуусахаас 90 хоногийн өмнө газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар хянуулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар нөөцийг хүлээн авах эсэх талаар шийдвэр гаргуулна.

32.3.Гэрээлэгч газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу орд ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар хянуулна.

32.4.Гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, тус зөвлөлөөс гаргасан дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн газрын тосны асуудал эрхэлсэн

төрийн захиргааны төв байгууллага газрын тос, уламжлалт бус газрын тосны орд ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг батална.

32.5.Гэрээлэгч болон газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хүсэлтээр баялгийн үнэлгээ, нөөцийн тооцоо, эдийн засгийн үнэлгээ, газрын тос, уламжлалт бус газрын тосны орд ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хөндлөнгийн байгууллага, эсхүл шинжээчээр дүгнэлт гаргуулахтай холбогдон гарах зардлыг гэрээлэгч хариуцна.

33 дугаар зүйл. Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, сунгах

33.1.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь газрын тос, уламжлалт бус газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 29.10-д заасны дагуу байгуулагдсан гэрээг үндэслэн олгоно.

33.2.Гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тосны нөөцийг хүлээн авах тухай газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш 180 хоногийн дотор ашиглалтын үйл ажиллагаа явуулах тухай хүсэлт гаргана.

33.3.Гэрээлэгч ашиглалт эхлэхээс өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөл авах бөгөөд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс ашиглалтын хугацаа эхэлнэ.

33.4.Гэрээлэгч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад дараах баримт бичгийг бүрдүүлж газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ:

33.4.1.газрын тос, уламжлалт бус газрын тосны нөөцийг хүлээн авч, бүртгэсэн тухай газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр;

33.4.2.газрын тос, уламжлалт бус газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө;

33.4.3.эрх бүхий төрийн захиргааны байгууллагаас баталсан нэг загварын байр зүйн зураг дээр ашиглалтын талбайн булангийн цэгүүдийн солбицлыг градус, секундээр тодорхойлж тэмдэглэсэн зураг.

33.5.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 14 хоногийн дотор ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгох, сунгах эсэх тухай шийдвэрийг гаргаж, гэрээлэгчид хариу мэдэгдэх бөгөөд ашиглалтын тусгай зөвшөөрлийг ашиглалтын хугацаагаар гэрээлэгчид олгож, сунгана.

33.6.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тохиолдолд гэрээлэгч дараах баримт бичгийг бүрдүүлэн газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар дамжуулан газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх бөгөөд төрийн захиргааны төв байгууллага 30 хоногийн дотор ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгох эсэхийг шийдвэрлэнэ:

33.6.1.ашиглалтын хугацаанд гүйцэтгэсэн ажлын нэгдсэн тайлан;

33.6.2.байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын тайлан;

33.6.3.сунгасан хугацаанд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл.

33.7.газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 33.6-д заасан баримт бичгийг хянаж хугацааг сунгах үндэслэлтэй гэж үзвэл энэ хуульд заасан хугацаагаар сунгаж, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон хүсэлт гаргасан гэрээлэгчид ажлын 5 хоногт мэдэгдэнэ.

33.8. Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон нь ашиглалтын талбайг улсын тусгай хэрэгцээнд авах үндэслэл болох бөгөөд тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 90 хоногийн дотор энэ хуулийн 33.4.3-т заасны дагуу ашиглалтын талбайн хилийн хэмжилт хийж, шав тэмдэг тавих ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

33.9.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон болон сунгасан талаар тухайн нутгийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

34 дүгээр зүйл.Газрын тос, уламжлалт бус газрын тосны ашиглалт

34.1.Гэрээлэгч нөөцийн тооцоо, тайланг хуульд заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлэн, нөөцийг баталж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн тухай шийдвэрийг гэрээлэгчид мэдэгдсэн өдрөөс хойш 90 хоногийн дотор ашиглалтын үйл ажиллагаа явуулах эсэх тухай хүсэлт гаргаагүй тохиолдолд гэрээг дуусгавар болгож, тухайн талбайд ашиглалт явуулах этгээдийг энэ хуульд заасны дагуу нээлттэй сонгон шалгаруулалтаар тодруулна.

34.2.Газрын тосны ашиглалтын хугацаа 25 хүртэл жил байх бөгөөд гэрээлэгч ашиглалтын хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тохиолдолд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 5 хүртэл жилээр хоёр удаа сунгаж болно.

34.3.Уламжлалт бус газрын тосны ашиглалтын хугацаа 30 хүртэл жил байх бөгөөд гэрээлэгч ашиглалтын хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тохиолдолд энэ хуулийн 34.2-т заасны дагуу сунгаж болно.

34.4.Газрын тос, уламжлалт бус газрын тосны орд, хураагуур нь хоёр ба түүнээс дээш ашиглалтын талбайн хил заагийг дамнан байрших тохиолдолд гэрээлэгчид нь хамтран ашиглах гэрээ байгуулан ашиглалтын нэгдсэн төлөвлөгөө, төсөв боловсруулж газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар батлуулна.

34.5.Гэрээлэгч нь энэ хуулийн 34.4-д заасныг хэрэгжүүлэхээс татгалзсан тохиолдолд тухайн орд, хураагуурыг хэрхэн ашиглах талаарх шийдвэрийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох хууль тогтоомж, шинжлэх ухааны аргачлалд үндэслэн шийдвэрлэнэ.

34.6.Гэрээлэгч ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 90 хоногийн дотор ашиглалтын эхний жилийн төлөвлөгөө, төсвийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар батлуулна.

34.7.Гэрээлэгч ашиглалтын хоёр дахь жилээс эхлэн тухайн жилийн ашиглалтын төлөвлөгөө, төсвийн төслийг хуанлийн өмнөх жил дуусахаас 30 хоногийн өмнө газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлэх бөгөөд төрийн захиргааны байгууллага нь дараа жилийн эхний улиралд багтаан батална.

34.8.Гэрээлэгч энэ хуулийн 10.1.7-д зааснаар тохиролцсон талбайд энэ хуулийн 32.2-д заасан шийдвэрт тусгагдсан нөөцөөс ашиглалтын үйл ажиллагаа явуулна.

35 дугаар зүйл.Төслийн үйл ажиллагаа саатсан тохиолдолд хугацааг хойшлуулах

35.1.Хайгуул, үнэлгээ, бүтээн байгуулалт, эсхүл ашиглалтын үйл ажиллагаа давагдашгүй хүчин зүйл, гэрээлэгчээс үл хамаарах иргэдийн эсэргүүцэл, эсхүл төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, эс үйлдэхүйн улмаас саатсан бол гэрээлэгчийн хүсэлтээр уг саатсан хугацааг хайгуул, ашиглалтын хугацаанаас хасаж тооцно.

35.2.Энэ хуулийн 35.1-д заасан саатсан хугацаанд ногдох гэрээний төлбөр, урамшуулал, хайгуулын ажлын доод хэмжээний үүргийн биелэлтийн хугацааг тухайн нөхцөл байдал үргэлжилсэн хугацаатай тэнцэх хугацаагаар хойшлуулж, хайгуул, ашиглалтын хугацааны хуваарьт зохих өөрчлөлтийг оруулна.

35.3.Гэрээлэгч саатал үүссэн нөхцөл байдлыг нотлох баримтыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. Төрийн захиргааны байгууллага уг нөхцөл байдлыг 30 хоногийн дотор хянан үзэж, үйл ажиллагаа саатсан хугацааг баталгаажуулан хайгуул, ашиглалтын хугацааг сунгах, гэрээний үүргийн биелэлтийн хуваарийг шинэчлэх шийдвэр гаргана.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ТЭЭВЭРЛЭЛТ, ХАДГАЛАЛТ, ТАЛБАЙ БУЦААЛТ

36 дугаар зүйл.Талбай буцаалт

36.1.Гэрээлэгч хайгуулын үндсэн хугацаа болон сунгалтын хугацаанд өөрийн хүсэлтээр, эсхүл гэрээнд заасан хувь хэмжээгээр талбайг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн буцаан өгөх бөгөөд холбогдох хайгуул, судалгааны ажлын анхдагч болон боловсруулсан тайлан, өгөгдөл, дээж, сорьц, материалыг цахим болон хэвлэмэл хэлбэрээр газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө.

36.2.Нээлт хийгдэж, үнэлгээний хөтөлбөр хэрэгжиж буй талбай болон ашиглалтын талбайд энэ хуулийн 36.1-д заасан талбайн хэсэгчилсэн буцаалтын зохицуулалт хамаарахгүй.

36.3.Гэрээлэгч гэрээт талбайг бүхэлд нь буцаан өгөх тохиолдолд буцаан авах шийдвэр гарсан өдрийг хүртэл үүссэн тусгай зөвшөөрлийн төлбөр, гэрээний урамшууллыг бүрэн төлөх ба энэ хуулийн 14.1.5-д заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг стандартын дагуу бүрэн хийж дуусгах, татан буулгах ажлын зардлыг хариуцан биелүүлнэ.

36.4.Гэрээлэгч гэрээт талбайг бүхэлд нь төрд хүлээлгэн өгсөн тухай шийдвэр гарсан өдрөөс хойших үлдсэн хайгуулын жилүүдэд хамаарах хайгуулын ажлын доод хэмжээний үүрэг, тусгай зөвшөөрлийн төлбөр, урамшуулал болон ирээдүйд үүсэх бусад гэрээний үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

36.5.Гэрээлэгч талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан өгөх эцсийн шийдвэр гарах хүртэл тухайн буцаан өгөх талбайд ногдох тусгай зөвшөөрлийн төлбөрийг бүрэн төлөх үүрэгтэй бөгөөд талбай буцаахтай холбогдон гарах зардлыг гэрээлэгч бүрэн хариуцна.

37 дугаар зүйл.Газрын тос, уламжлалт бус газрын тосыг хадгалах

37.1.Олборлосон газрын тос, уламжлалт бус газрын тосыг дараах байдлаар хадгалж болно:

37.1.1.газрын тос, уламжлалт бус газрын тос хадгалах байгууламж барьж ашиглах;

37.1.2.гэрээт талбайд байгалийн байдлаараа оршиж байгаа газрын тос, уламжлалт бус газрын тосны хураагуурын орон зайг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авч ашиглах.

37.2.Энэ хуулийн 37.1.2-т заасан хураагуурт газрын тос, уламжлалт бус газрын тосыг юүлэх болон буцаан гаргахдаа холбогдох дүрэм, журамд заасны дагуу хэмжинэ.

37.3.Газрын тос, уламжлалт бус газрын тосыг зориулалтын бус барилга байгууламжид хадгалахыг хориглоно.

37.4.Энэ зүйлийн 37.3 дахь заалтад олборлолтын туршилт, туршилтын олборлолтын үед ашиглах түр сав, байгууламж хамаарахгүй.

38 дугаар зүйл.Газрын тос, уламжлалт бус газрын тосыг тээвэрлэх

38.1.Олборлосон газрын тос, уламжлалт бус газрын тосыг төмөр зам, тусгай зориулалтын автомашин, эсхүл дамжуулах хоолойгоор тээвэрлэнэ.

38.2.Гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тосыг тусгай зориулалтын автомашинаар тээвэрлэх тохиолдолд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан замын төрөл, стандартыг мөрдөнө.

38.3.Гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тосыг борлуулах зориулалт бүхий дамжуулах хоолой барих бол энэ тухай хүсэлтээ газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

38.4.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 38.3-т заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш 3 сарын дотор саналаа Засгийн газарт хүргүүлж, зохих шийдвэр гаргуулна.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ХЯНАЛТ, БҮРТГЭЛ, ХЭМЖИЛТ

39 дүгээр зүйл.Үйл ажиллагааны тайлан, мэдээллийг хүлээн авах

39.1.Гэрээлэгч энэ хуулийн 10.1.13-т заасан мэдээллийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад үнэ төлбөргүйгээр, цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүлээлгэн өгнө.

39.2.Энэ хуулийн 39.1-д заасан мэдээллийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээн авч цахим мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

39.3.Гэрээлэгч судалгаа, боловсруулалт, тайлал, лабораторийн туршилт, шинжилгээ хийх зорилгоор газрын тос, уламжлалт бус газрын тос, хий, шингэн, чулуун дээж болон анхдагч мэдээ материалыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авч, Монгол Улсын хилээр нэвтрүүлнэ.

39.4.Гэрээлэгч Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн газрын тос, уламжлалт бус газрын тос, хий, шингэн, чулуун дээжийн шинжилгээний үр дүн болон чулуун дээж, анхдагч мэдээ материалыг судалгаа, шинжилгээний ажил дууссанаас хойш 180

хоногийн дотор газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө.

40 дүгээр зүйл.Хэмжилтийн цэг болон хүргэлтийн цэгийг ажиллуулах

40.1.Газрын тос, уламжлалт бус газрын тосны хүргэлтийн цэгийг худалдан авагчийн саналыг үндэслэн газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, гэрээлэгч харилцан тохиролцож тогтооно.

40.2.Газрын тос, уламжлалт бус газрын тосны хэмжилтийн цэгийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, гэрээлэгч нар харилцан тохиролцож тогтооно. Хэрэв хэмжилтийн цэгийн байршлын талаар талууд 30 хоногийн дотор тохиролцож чадаагүй бол газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэмжилтийн цэгийг тогтооно.

40.3.Хүргэлтийн цэг болон хэмжилтийн цэг дээр хөндлөнгийн эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэнэ.

40.4.Хэмжилтийн болон хүргэлтийн цэг дээр Хэмжил зүйн тухай хууль тогтоомжид заасан стандарт, техникийн шаардлага хангасан, эрх бүхий байгууллагаар баталгаажсан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг гэрээлэгч өөрийн хөрөнгөөр барьж байгуулна.

40.5.Хөндлөнгийн эрх бүхий мэргэжлийн байгууллага нь борлуулсан нийт газрын тос, уламжлалт бус газрын тосны тоо хэмжээ, чанарыг хэмжилтийн болон хүргэлтийн цэг дээр хэмжиж, түүний мэдээллийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, гэрээлэгч, худалдан авагчид хүргүүлнэ. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага уг мэдээллийг цахим мэдээллийн нэгдсэн санд тогтмол бүртгэнэ.

40.6.Хэмжилт болон хүргэлтийн цэгийн тоолуур, хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа, баталгаажуулалтад газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон хэмжил зүйн асуудал эрхэлсэн байгууллага хамтран хяналт тавина.

40.7.Газрын тос, уламжлалт бус газрын тос тээвэрлэх, дамжуулах шугам хоолойн үйл ажиллагааны явцад гарах технологийн алдагдлын зөвшөөрөгдөх дээд хязгаар, хэвийн хорогдлын хэмжээнээс хэтэрсэн алдагдлыг гэрээлэгчийн борлуулсан бүтээгдэхүүнд тооцож, газрын тосны нөөц ашигласны төлбөр, татварыг нөхөн ногдуулна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ӨРТӨГ НӨХӨХ ЗАРДЛЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТ, ТӨЛБӨР ХУРААМЖ

41 дүгээр зүйл.Мэдээ тайлан гаргах

41.1.Гэрээлэгч нь тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалт, гаргасан зардал, нөөц ашигласны төлбөр, олборлосон болон борлуулсан газрын тос, уламжлалт бус газрын тосны хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татварын хэмжээг дараа оны нэгдүгээр улиралд багтаан холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

41.2.Гэрээлэгч нь гэрээт талбайд явуулж буй газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон бүх үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнана.

42 дугаар зүйл.Хяналт шалгалт, баталгаажуулалт

42.1.Хэрэв гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааг Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу явуулж буй тохиолдолд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага анхан шатны баримтад үндэслэн гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тос, уламжлалт бус газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайланг хянан шалгаж, гаргасан дүгнэлтийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

42.2.Энэ хуулийн 42.1-д заасны дагуу төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн дүгнэлтийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж баталгаажуулна.

42.3.Энэ хуулийн 42.2-т заасан өртөг нөхөх зардлын баталгаажуулалт нь зөвхөн өртөг нөхөлтийн зорилготой бөгөөд тухайн хөрөнгө оруулалт бодитоор гарсан эсэх, зардлын гүйлгээ хийгдсэн эсэхийг баталгаажуулна.

42.4.Энэ хуулийн 42.3-т заасан баталгаажуулалт нь гэрээлэгчээс ажлыг чанартай гүйцэтгэсэн, эсхүл хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн биелүүлсэн гэдгийг тогтоох, тухайн үйл ажиллагаанд төрөөс хяналт шалгалт хийх эрх зүйн үндэслэлийг хязгаарлах шалтгаан болохгүй.

43 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийн төлбөр, түүнийг хуваарилах

43.1.Гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын болон ашиглалтын үед тусгай зөвшөөрлийн төлбөрийг жил бүр төлнө.

43.2.Хайгуулын тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр нь гэрээт талбайн нэг хавтгай дөрвөлжин километр тутамд гурван америк доллартай тэнцэх хэмжээний төгрөг байна.

43.3.Хайгуулын хугацааг сунгасан тохиолдолд тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр нэг хавтгай дөрвөлжин километр тутамд найман америк доллартай тэнцэх хэмжээний төгрөг байна.

43.4.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр нь нэг хавтгай дөрвөлжин километр тутамд 100 америк доллартай тэнцэх хэмжээний төгрөг байна.

43.5.Ашиглалтын хугацааг сунгасан тохиолдолд гэрээт талбайн жилийн төлбөр нэг хавтгай дөрвөлжин километр тутамд 200 америк доллартай тэнцэх хэмжээний төгрөг байна.

43.6.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн жилийн төлбөрийг арилжааны олборлолт эхэлсэн өдрөөс тооцно.

43.7.Тусгай зөвшөөрлийн төлбөрийг тухайн гэрээт талбай орших сум, дүүрэгт төвлөрүүлнэ.

43.8.Тусгай зөвшөөрлийн төлбөрийг тухайн санхүүгийн жил эхэлснээс хойш 45 хоногийн дотор төлнө.

43.9.Газрын тосны төрийн өмчит компани нь Засгийн газраас олгосон талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах үед тусгай зөвшөөрлийн төлбөр төлөхгүй.

44 дүгээр зүйл.Газрын тосны нөөц ашигласны төлбөр ногдуулах

44.1.Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь борлуулсан газрын тосны 5-12 хувь байна.

44.2.Уламжлалт бус газрын тосны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь борлуулсан газрын тосны 5-8 хувь байна.

44.3.Нөөц ашигласны төлбөрийг Төсвийн тухай хуульд заасны дагуу төвлөрүүлнэ.

44.4.Газрын тос, уламжлалт бус газрын тосны үнийг шинж чанар, зах зээл, байршил, өрсөлдөх чадвар зэргээс хамааруулан худалдан авагчийн саналыг үндэслэн газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгч харилцан тохиролцож тогтооно.

45 дугаар зүйл.Эрх зүйн тогтвортой байдлыг хангах

45.1.Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацаанд татварын хууль тогтоомжид өөрчлөлт орж, татварын хувь хэмжээ нэмэгдсэн тохиолдолд гэрээлэгчийн татвар, төлбөрийг тухайн гэрээ байгуулсан өдрийн хууль тогтоомжийн дагуу тогтвортой мөрдөнө.

45.2.Энэ хуулийн 45.1-д заасан зохицуулалт нь байгаль орчныг хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шинэчлэгдсэн стандартад хамаарахгүй бөгөөд гэрээлэгч тэдгээрийг тухай бүр дагаж мөрдөх үүрэгтэй.

46 дугаар зүйл.Төлбөр, урамшууллын хязгаарлалт

46.1.Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаатай холбогдуулан гэрээлэгчээс энэ хууль болон Татварын ерөнхий хуульд заасан нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөр, сургалтын урамшууллаас бусад аливаа төлбөр, хураамж, урамшуулал, хандив, тусламж, эсхүл нэр төрөл үл харгалзан төрийн болон орон нутгийн байгууллагын нэрээр төлбөр, хураамж авахыг хориглоно.

46.2.Энэ хуулийн 46.1-д заасан төлбөр, хураамж, хандив, тусламжийг бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан аливаа хэлбэрээр шаардах, гэрээлэгчээс нэмэлт төлбөр нэхэмжлэхийг хориглоно.

АРАВДУГААР БҮЛЭГ

ОРОН НУТГИЙН ХАРИЛЦАА, ИРГЭДИЙН ОРОЛЦОО

47 дугаар зүйл.Хамтын ажиллагааны гурвалсан гэрээ байгуулах

47.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагаа эхлэхээс өмнө Хамтын ажиллагааны гурвалсан гэрээг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон гэрээт талбай орших сум, дүүргийн Засаг даргатай жил бүр байгуулна.

47.2.Гэрээлэгч энэ хуулийн 47.1-д заасан Хамтын ажиллагааны гурвалсан гэрээг байгуулаагүй, эсхүл гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь гэрээлэгчийн үйл ажиллагааг эхлүүлэхээс татгалзах, эсхүл үйл ажиллагааг түр зогсоох үндэслэл болно.

47.3.Хэрэв гэрээт талбай нь хоёр болон түүнээс дээш сумын нутаг дэвсгэрийг хамарсан тохиолдолд гэрээлэгч нь тухайн жилийн ашиглалтын үйл ажиллагаа явагдах сум, дүүргийн Засаг даргатай уг гэрээг байгуулна.

47.4.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Хамтын ажиллагааны гурвалсан гэрээний дагуу бүтээгдэхүүн хуваах гэрээний хувьд гэрээлэгчид ногдох ашигт тосны ... хүртэлх хувьтай, бусад гэрээний хувьд гэрээлэгчид ногдох борлуулалтын орлогын ... хүртэлх хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг энэ хуулийн 47.3-т заасан сум, дүүргийн төсөвт шууд шилжүүлж, төвлөрүүлнэ.

47.5.Тухайн сум, дүүргийн Засаг дарга нь Хамтын ажиллагааны гурвалсан гэрээний дагуу хийгдсэн санхүүжилтийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглох бөгөөд энэхүү гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн зарцуулалтын тайланг жил бүр дээд шатны Засаг дарга, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгчид хүргүүлнэ.

47.6.Хэрэв гэрээт талбайд онц байдал, давагдашгүй хүчин зүйл, орон нутгийн эсэргүүцэл эсхүл төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаа, эс үйлдэхүйн улмаас гэрээний дагуу ажил үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн бол тухайн жилд энэ хуульд заасан Хамтын ажиллагааны гурвалсан гэрээг байгуулахгүй бөгөөд гэрээлэгч нь энэ тухайгаа газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тухайн сум, дүүргийн Засаг даргад урьдчилан мэдэгдэнэ.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ГОМДОЛ ГАРГАХ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

48 дугаар зүйл.Гэрээний маргааныг шийдвэрлэх

48.1.Газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагааны хүрээнд байгуулсан гэрээг тайлбарлах, хэрэглэх, хүчин төгөлдөр байдлыг тогтооход зөвхөн Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөнө.

48.2.Гэрээлэгч болон Төрийн байгууллагын хооронд үүссэн гэрээний аливаа маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэхийг урьтал болгоно.

48.3.Талууд маргааныг харилцан тохиролцож шийдвэрлэж чадаагүй тохиолдолд маргааныг Монгол Улсын шүүх, эсхүл талууд гэрээгээр харилцан тохиролцсон олон улсын арбитраар эцэслэн шийдвэрлүүлнэ.

49 дүгээр зүйл.Захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэрт гомдол гаргах

49.1.Гэрээлэгч, оператор, туслан гүйцэтгэгч болон иргэдийн хууль ёсны эрх ашиг, сонирхол нь төрийн захиргааны байгууллага, төрийн захиргааны төв байгууллага болон тэдгээрийн албан тушаалтны гаргасан захиргааны акт, үйл ажиллагаа, үйлдэл, эс үйлдэхүйн улмаас зөрчигдсөн гэж үзвэл Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу дээд шатны албан тушаалтан, байгууллагад гомдол гаргах эрхтэй.

49.2.Энэ хуулийн 49.1-т заасны дагуу гаргасан гомдлыг хүлээн авсан дээд шатны байгууллага, албан тушаалтан Захиргааны ерөнхий хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэж, хариуг бичгээр өгөх үүрэгтэй.

49.3.Гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэрийг эс зөвшөөрвөл маргааныг Захиргааны хэргийн шүүхэд гаргаж шийдвэрлүүлнэ.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ

ХАРИУЦЛАГА

50 дугаар зүйл.Төрийн байгууллага, албан тушаалтны хүлээх хариуцлага

50.1.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэрээлэгчээс ирүүлсэн жилийн ажлын төлөвлөгөө, төсөв, тайлан, хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 30 өдрийн дотор хянан шийдвэрлэх үүрэгтэй.

50.2.Шаардлагатай баримт бичиг дутуу, эсхүл техникийн болон санхүүгийн нэмэлт тодруулга хийхээс бусад үндэслэлээр энэ хуулийн 50.1-т заасан хугацааг хэтрүүлэхийг хориглох бөгөөд хугацаа үндэслэлгүй хэтрүүлсэн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

50.3.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

51 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хохирол барагдуулах

51.1.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

51.2.Хууль зөрчсөн үйлдлийн улмаас төр болон орон нутаг, иргэдэд учруулсан эд хөрөнгийн болон байгаль орчны хохирлыг буруутай этгээд Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу бүрэн нөхөн төлөх үүрэгтэй.

51.3.Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй, эсхүл хуульд заасан хугацаанд шийдвэр гаргаагүйн улмаас гэрээлэгчид учирсан бодит хохирлыг Захиргааны ерөнхий хууль болон Иргэний хуульд заасан журмын дагуу төрийн холбогдох байгууллага барагдуулна.

51.4.Энэ хуулийн 51.3-т заасан нөхцөл байдал болон бусад гуравдагч этгээдийн хууль бус үйл ажиллагааны улмаас газрын тос, уламжлалт бус газрын тосны үйл ажиллагаа саатсан, түдгэлзсэн тохиолдолд гэрээ, тусгай зөвшөөрөл, тухайн жилийн ажлын төлөвлөгөө, төсөв болон үүрэг гүйцэтгэх хугацааг сунгаж, хойшлуулах харилцааг энэ хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэх бөгөөд уг саатлыг гэрээлэгчийн үүргийн зөрчилд тооцохгүй.

51.5.Иргэн, хуулийн этгээдийн хууль бус үйлдлийн улмаас гэрээлэгчийн үйл ажиллагаа тасалдсан, эд хөрөнгө, дэд бүтэц, хөрөнгө оруулалтад хохирол учирсан бол буруутай этгээдээр бодит хохирол болон нэмэлт зардлыг Иргэний хуулийн дагуу бүрэн нөхөн төлүүлнэ.

АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

52 дугаар зүйл.Захиргааны хэм хэмжээний акт батлах

52.1.Энэ хуулийг дагаж мөрдөхтэй холбогдуулан Засгийн газар болон газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, холбогдох бусад төрийн захиргааны төв байгууллагаас батлах захиргааны хэм хэмжээний актыг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хоёр жилийн дотор багтаан эцэслэн батална.

52.2.Энэ хуулийн 52.1-д заасан журмууд хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд урьд нь мөрдөгдөж байсан журмуудын энэ хуульд зөрчигдөхгүй хэсгийг түр хугацаанд дагаж мөрдөнө.

53 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

53.1.Энэ хуулийг 202... оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**1 дүгээр зүйл.Хуулийн зорилго**

1.1.Энэ хуулийн зорилго нь Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөхтэй холбогдуулан шилжилтийн үеийн харилцааг зохицуулах, өмнө байгуулсан эрлийн болон Бүтээгдэхүүн хуваах гэрээ, тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байдлыг хадгалах, шинэ гэрээний тогтолцоонд шилжих, өртөг нөхөх зардлыг эцэслэх, мэдээллийн сан болон татан буулгалтын баталгааны хөрөнгийг шилжүүлэх, дагаж мөрдөх дүрэм, журмыг батлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хууль тогтоомжийн уялдаа, өмнө байгуулагдсан гэрээ, тусгай зөвшөөрлийн үйлчлэл

2.1.Энэ хууль нь Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн салшгүй хэсэг бөгөөд шилжилтийн үеийн харилцаанд тухайн хуультай хамт хэрэглэнэ.

2.2.1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн болон 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн Газрын тосны тухай хуулийн дагуу байгуулагдсан, хүчин төгөлдөр үйлчилж байгаа Бүтээгдэхүүн хуваах гэрээ, эрлийн гэрээ болон тэдгээрийн үндсэн дээр олгогдсон хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлүүд нь тухайн гэрээнд заасан хугацаа дуусах хүртэл хууль ёсны хүчин төгөлдөр хэвээр үргэлжилнэ.

2.3.Энэ хуулийн 2.2-т заасан гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахад гэрээлэгчийн татвар, төлбөр, өртөг нөхөх зардал болон бүтээгдэхүүн хуваах нөхцөлд тухайн гэрээг байгуулах үед мөрдөж байсан хууль тогтоомж болон гэрээний заалтууд хугацаа дуустал хэвээр үйлчилнэ.

2.4.Энэ хуулийн 2.2-т заасан Бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацааг сунгах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл гэрээний эрх, үүргийг бусдад шилжүүлэх харилцааг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

2.5.Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулсан эрлийн гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд эрлийн ажлын үр дүнгийн тайланг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар хянуулан дүгнэлт гаргуулсны дараа Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 18 дугаар зүйлд заасан гэрээний аль нэг төрлөөр хайгуулын гэрээ байгуулах саналыг батлагдсан журмын дагуу гаргаж болно.

3 дугаар зүйл. Өртөг нөхөх зардлыг эцэслэх

3.1.Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болохоос өмнөх санхүүгийн жилүүдэд хамаарах, гэрээлэгчээс тайлагнасан боловч эцэслэн баталгаажгаагүй өртөг нөхөх зардлын тайланд хийх төрийн аудитын шалгалтыг өмнө

мөрдөж байсан журмын дагуу гүйцэтгэж, энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 1 /нэг/ жилийн дотор багтаан эцэслэн баталгаажуулна.

3.2.Өртөг нөхөх зардлын аудиттай холбоотой маргааныг шилжилтийн хугацаанд талууд харилцан зөвшилцөж, аудитын тэмдэглэл болон протоколоор эцэслэн шийдвэрлэнэ.

4 дүгээр зүйл. Шинэ гэрээний тогтолцоонд шилжих

4.1.Энэ хуулийн 2.2-т заасан гэрээлэгч өөрийн хүсэлтээр Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 19 дүгээр зүйлд заасан журмын дагуу шинэ төрлийн гэрээнд сайн дураар шилжиж болно.

4.2.Шинэ төрлийн гэрээнд шилжих тохиолдолд өмнөх Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу баталгаажсан боловч нөхөгдөөгүй үлдсэн өртөг нөхөх зардлын үлдэгдлийг шинэ гэрээний нөхцөлтэй уялдуулан тооцох журмыг шилжилтийн тусгай гэрээгээр баталгаажуулна.

5 дугаар зүйл.Мэдээллийн сангийн шилжилт

5.1.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь газрын тос болон уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын анхдагч мэдээлэл, геологи, геофизик, өрөмдлөгийн өгөгдөл, тайлан болон бусад мэдээллийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан цахим мэдээллийн нэгдсэн санд энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 1 /нэг/ жилийн дотор бүрэн шилжүүлнэ.

6 дугаар зүйл.Татан буулгалтын баталгааны хөрөнгийг шилжүүлэх

6.1.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө мөрдөж байсан хууль тогтоомжийн дагуу Байгаль орчныг хамгаалахтай холбоотой тусгай сан, дансанд байршуулсан татан буулгалт, нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгийг энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 60 хоногийн дотор Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх арилжааны банканд нээсэн гурвалсан хяналт бүхий тусгай дансанд шилжүүлнэ.

7 дугаар зүйл. Шилжилтийн үеийн маргаан

7.1.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулсан гэрээтэй холбоотой шилжилтийн үеийн маргааныг тухайн гэрээ болон энэ хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

8 дугаар зүйл.Дагаж мөрдөх дүрэм, журам батлах

8.1.Засгийн газар болон газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, холбогдох бусад төрийн байгууллага Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 52 дугаар зүйлд заасан захиргааны хэм хэмжээний актыг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 2 /хоёр/ жилийн дотор багтаан боловсруулж батална.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан захиргааны хэм хэмжээний акт батлагдаж мөрдөгдөх хүртэл өмнө нь мөрдөж байсан журмуудын Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д зөрчигдөхгүй хэсгийг шилжилтийн хугацаанд түр мөрдөнө.

9 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

9.1.Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлд 60.13, 60.14 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт 23.6.11 дэх заалт, 23.8 дахь хэсэгт 23.8.14 дэх заалт, 23.9 дэх хэсэгт 23.9.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт 60.2.11, 60.2.12 дахь заалт тус тус нэмсүгэй:

1/60 дугаар зүйлийн 60.13, 60.14 дэх хэсэг:

“60.13.Энэ хуулийн 60.2.11-д заасан газрын тос, уламжлалт бус газрын тосны тусгай зөвшөөрлийн жилийн төлбөрийг төлөгдсөн өдрөөс хойш 45 хоногийн дотор Төрийн сангийн цахим системээр дамжуулан тухайн гэрээт талбай орших сум, дүүргийн төсвийн дансанд суутган хуваарилна.

60.14.Энэ хуулийн 60.2.12-т заасан Хамтын ажиллагааны гурвалсан гэрээний санхүүжилтийг сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн дэд бүтэц, нийгмийн салбар, байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зориулан зарцуулах бөгөөд зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.”

2/ 23 дугаар зүйлийн 23.6.11 дэх заалт:

“23.6.11. газрын тос, уламжлалт бус газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 20 хувь;”

2/23 дугаар зүйлийн 23.8.14 дэх заалт:

“23.8.14. газрын тос, уламжлалт бус газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30 хувь;”

3/23 дугаар зүйлийн 23.9.4 дэх заалт:

“23.9.4.Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан Хамтын ажиллагааны гурвалсан гэрээний дагуу тухайн сум, дүүргийн төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө.”

4/60 дугаар зүйлийн 60.2.11 дэх заалт:

“60.2.11.Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт хамаарах газрын тос, уламжлалт бус газрын тосны тусгай зөвшөөрлийн жилийн төлбөрийн орлого;”

4/60 дугаар зүйлийн 60.2.12 дахь заалт:

“60.2.12.Энэ хуулийн 23.9.4 дэх хэсэгт заасан мөнгөн хөрөнгө”

2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.11, 23.8.13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/23 дугаар зүйлийн 23.4.11 дэх заалт:

“23.4.11. газрын тос, уламжлалт бус газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 50 хувь;”

2/23 дугаар зүйлийн 23.8.13 дахь заалт:

“23.8.13.Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт хамаарах газрын тос, уламжлалт бус газрын тосны тусгай зөвшөөрлийн жилийн төлбөрийн орлого.”

3 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.12, 23.6.9 дэх заалт, 59 дүгээр зүйлийн 59.1.5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.4 дэх хэсэг нэмсүгэй:

“3.4. Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан газрын тос, уламжлалт бус газрын тос /нүүрсний давхаргын метан хий, шатдаг занар гэх мэт/-ны хайгуул, ашиглалт, борлуулалттай холбогдсон харилцаанд энэ хууль үйлчлэхгүй.”

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “газрын тос,” гэсний дараа “уламжлалт бус газрын тос,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.7, 35.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/35 дугаар зүйлийн 35.7 дахь хэсэг:

“35.7. Нүүрсний тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн аюулгүй ажиллагааг хангах, агааржуулалт, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор нүүрсний уурхайн метан хийг зайлуулах, цуглуулах, ашиглах эрхтэй бөгөөд энэ нь нүүрсний давхаргын метан хийг арилжааны зорилгоор хайх, олборлох, нөөц бүртгүүлэх, борлуулах эрхийг үүсгэхгүй.”

2/35 дугаар зүйлийн 35.8 дахь хэсэг:

“35.8. Нүүрсний тусгай зөвшөөрөл бүхий талбайд Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасны дагуу нүүрсний давхаргын метан хийн тусгай зөвшөөрөл олгогдсон тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Газрын тосны тухай хуульд заасан Талбай хамтран ашиглах гэрээг байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, үйл ажиллагааны дарааллыг харилцан уялдуулж ажиллана.”

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.3, 15.4, 15.5 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн хүснэгтийн 4 дэх мөр, 17.16 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.6, 19.7 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1.16 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.8.1 дэх заалт, 26 дугаар зүйлийн 26.9, 26.11 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.3.2 дахь заалтын “г” дэд заалт, 30 дугаар зүйлийн 30.2, 30.6 дахь хэсэг, 30.10.1 дэх заалтын “газрын” гэсний дараа “тос, уламжлалт бус газрын” гэж, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.3.2 дахь заалтын “г” дэд заалтын “газрын тос” гэсний дараа “, уламжлалт бус газрын тос” гэж, 22 дугаар зүйлийн 22.8.1 дэх заалтын “хайгуул хийх,” гэсний дараа “олборлох,” тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/21 дүгээр зүйлийн 21.1.4 дэх заалт:

“21.1.4. Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Орлого хуваах гэрээ болон Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 5.3-т заасан гэрээний дагуу тус улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгч, түүний оператор компанийн өөрт ногдох бүтээгдэхүүн, борлуулалтын орлого,”

2/22 дугаар зүйлийн 22.8.4 дэх заалт:

“22.8.4. газрын тос, уламжлалт бус газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, газрын тос, уламжлалт бус газрын тос хайх, олборлох, борлуулах,”

3 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.13 дахь хэсгийн “Ашигт малтмал болон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч, Газрын тосны тухай хуульд заасан гэрээлэгч” гэснийг “Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтын “Газрын тосны тухай хуулийн 4.1.8-д” гэснийг “Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 4.1.43-т” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалтын “Газрын тосны тухай хуулийн 11.1.4, 12.5-д” гэснийг “Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 13.1.5, 20.5-д” гэж, 15 дугаар зүйлийн 15.1.13 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.14 дэх хэсгийн “Газрын тосны тухай хуулийн 11.2.9-д” гэснийг “Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 14.1.6-д” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1.13 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.13 дахь хэсгийн “Газрын тосны тухай хууль” гэснийг “Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 13.1.30 дахь заалт нэмсүгэй:

“13.1.30.Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон Орлого хуваах гэрээний дагуу гэрээлэгч, оператор хуулийн этгээдээс газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд импортолсон болон дотоодоос худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ, борлуулсан бүтээгдэхүүн.”

2 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.25, 13.1.26 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/“13.1.25.Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан гэрээний дагуу газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулан импортолсон болон дотоодоос худалдан авсан тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоноглол, түүхий эд, материал, химийн болон тэсрэх бодис, сэлбэг хэрэгсэл;”

2/“13.1.26.Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасны дагуу шилжүүлсэн газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон анхдагч болон үр дүнгийн тайлан материал, өгөгдөл, дээж, сорьц болон газрын тос, уламжлалт бус газрын тос;”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.7 дахь хэсэг нэмсүгэй:

“8.7.Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгч, оператор хуулийн этгээдийн хувьцаа, эцсийн үр ашиг хүртэгчийн эрхийг шилжүүлэхэд ногдуулах татварыг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 21 дүгээр зүйлд заасан зарчмыг баримтлан тусгайлан зохицуулна.”

2 дугаар зүйл.Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “Цөмийн энергийн тухай хууль,” гэсний дараа “Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.48 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.10, 26.11, 26.12 дахь хэсгийн “газрын тос,” гэсний дараа “уламжлалт бус газрын тос,” гэж тус тус нэмсүгэй.

4 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.36 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2.11 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 34.15.1 дэх заалтын “газрын тосны” гэснийг “газрын тос, уламжлалт бус газрын тосны” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “хэвлийн” гэснийг “хэвлий /ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос/-н” гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “Ашигт малтмалын” гэснийг “Ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тосны” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.16, 38.1.17 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/38.1.16 дахь заалт:

“38.1.16.Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон Орлого хуваах гэрээний дагуу газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд зориулан импортолсон тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоноглол, түүхий эд, материал, химийн болон тэсрэх бодис, сэлбэг хэрэгсэл;”

2/38.1.17 дахь заалт:

“38.1.17.Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасны дагуу шилжүүлсэн газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон анхдагч болон үр дүнгийн тайлан материал, өгөгдөл, дээж, сорьц болон газрын тос, уламжлалт бус газрын тос;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“16.1.8. Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан гэрээний дагуу газрын тос, уламжлалт бус газрын тосны ашиглалтын зориулалтаар ашиглах гэрээт талбай;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 14 дэх заалт нэмсүгэй:

“14/Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон Орлого хуваах гэрээний дагуу газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын зориулалтаар ашиглаж байгаа газрыг газрын төлбөрөөс чөлөөлнө.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 7 дахь заалт нэмсүгэй:

“7/Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон Орлого хуваах гэрээний дагуу газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд ашиглаж байгаа барилга, байгууламж.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.4.6 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтын “газрын тос” гэсний дараа “, уламжлалт бус газрын тос” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 7.13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.13 дугаар зүйл.Газрын тосны тухай хууль зөрчих

1.Төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулаагүй, эсхүл зөвшөөрөлгүйгээр эрэл, судалгааны ажил хийсэн бол зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Газрын тос, уламжлалт бус газрын тосны тусгай зөвшөөрөлгүйгээр, эсхүл байгуулсан гэрээний хүрээнээс гадуур хайгуул, ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулсан бол зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулахыг хориглосон, хязгаарласан газар нутагт газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Уламжлалт бус газрын тосны олборлолтын үйл ажиллагааны явцад шавхалтаар гарсан формацын усыг зориулалтын бусаар задгайгаар ууршуулсан, эсхүл байгаль орчинд хохирол учруулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Гэрээлэгч, оператор хуульд заасан Хамтын ажиллагааны гурвалсан гэрээг байгуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан, эсхүл орон нутагт олгох дэмжлэг, төлбөрийг саатуулсан бол хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайлан, мэдээ материал, өгөгдөл, дээж, сорьцыг төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлсэн, эсхүл хилээр гаргасан бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч олборлосон газрын тос, уламжлалт бус газрын тосны хэмжээг нуун дарагдуулсан, эсхүл өртөг нөхөх зардлыг зохиомлоор өсгөсөн, эсхүл энэхүү зорилгоор хуурамч гэрээ байгуулсан, эсхүл үндэслэлгүй бага үнээр борлуулж борлуулалтын орлогыг санаатайгаар бууруулсан бол

учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хуулийн этгээдийг тухайн хугацаанд олсон орлогын 50 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Засгийн газарт ногдох түүхий тосыг болон гэрээлэгчид ногдох тосыг дотоодын боловсруулах үйлдвэрт хуульд заасан нөхцөлөөр нийлүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Гэрээлэгч нь байгаль орчныг нөхөн сэргээх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах, цооног хаах зардлын баталгааны хөрөнгийг хуульд заасан эскроу дансанд тогтоосон хугацаанд байршуулаагүй бол хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч туршилтын олборлолт явуулах, эсхүл баялаг, нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж бүртгүүлэх журам зөрчсөн бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.Гэрээлэгч хуульд заасан хугацаанд жилийн ажлын төлөвлөгөө, төсвөө батлуулаагүй, эсхүл гэрээнд заасан хайгуулын ажлын доод хэмжээг гүйцэтгээгүй бол хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

12.Хайгуул, ашиглалтын ажлын дээж, сорьц, шлих, чулуун дээж, анхдагч өгөгдлийг үрэгдүүлсэн, эсхүл устгасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

13.Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаандаа зөвшөөрөлгүй, эсхүл хориглосон химийн хорт бодис, бэлдмэл хэрэглэсэн, эсхүл технологийн горим, дүрэм, журмыг дагаж мөрдөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дотоодын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, Монгол Улсын иргэдийг сургах, ажилд авах, эсхүл санхүүгийн гүйлгээг Монгол Улсын арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

15.Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны мэдээ, тайлан, төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн гарчигт “ашигт малтмал” гэсний дараа “, газрын тос, уламжлалт бус газрын тос” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “ашигт малтмалын” гэсний дараа “, газрын тос, уламжлалт бус газрын тосны” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1.Тусгай зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөгдсөн гэрээт талбайн хилийн заагаас гадуур ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан, эсхүл ашигт малтмал, газрын тос, уламжлалт бус газрын тос олборлохоос өөр зориулалтаар хууль бусаар газрын хэвлийд халдсан, эсхүл геологийн анхдагч болон боловсруулсан стратегийн өгөгдөл, дээж, сорьцыг зөвшөөрөлгүйгээр гадаад улсад дамжуулсны улмаас үлэмж хэмжээний хохирол учруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.10 дахь заалт, 25.1.10.а., 25.1.10.б.3. 25.1.10.в. дэд заалтын “газрын тосны” гэснийг “газрын тос, уламжлалт бус газрын тосны” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 8.6.22 дахь заалт нэмсүгэй:

“8.6.22. Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан газрын тос, уламжлалт бус газрын тосны цахим мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл;”

2 дугаар зүйл. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.22 дахь заалтын дугаарыг “8.6.23.” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.6 дахь хэсэг нэмсүгэй:

“15.6.Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан өртөг нөхөх зардлын баталгаажуулалт нь зөвхөн гэрээний дагуу өртөг нөхөх санхүүгийн бодит гүйлгээг баталгаажуулах зорилготой бөгөөд Төрийн аудитын байгууллагаас хууль тогтоомжийн дагуу хийх аудитын хяналт, шалгалтын бүрэн эрхийг хязгаарлах шалтгаан болохгүй.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.5 дахь хэсэг нэмсүгэй:

“4.5. Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгч, оператор хуулийн этгээд нь нягтлан бодох бүртгэлээ Газрын тосны баялгийн менежментийн систем болон санхүүгийн олон улсын стандартад нийцүүлэн тусгайлсан журмаар хөтөлнө.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай “д” заалт нэмсүгэй:

“11.1.2.д. Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Орлого хуваах гэрээ болон Татвар-нөөц ашигласны төлбөрийн гэрээний дагуу төрд ногдох ашигт тос, төлбөр, урамшууллын орлого.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн төгсгөлд “Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан уламжлалт бус газрын тосны олборлолтын үйл ажиллагааны явцад гарсан формацын усыг буцаан хураагуурт шахах үйл ажиллагаанд энэ хэсэг хамаарахгүй.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн гарчиг, 5.1, 5.2, 5.3, 5.5, 5.6 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын “тосны” гэсний өмнө “тос, уламжлалт бус газрын” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3 дахь заалтын “газрын тос” гэсний дараа “, уламжлалт бус газрын тос” гэж, 4.1.9 дэх заалтын “газрын тос,” гэсний дараа “уламжлалт бус газрын тос,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“13.3.Энэ хуулийн 4.7-д заасан болон Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д зааснаас бусад тохиолдолд татварын хувь, хэмжээг тогтворжуулах асуудлыг зөвхөн энэ хууль болон энэ хуульд заасан хөрөнгө оруулалтын гэрээгээр зохицуулна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.9 дэх хэсэг нэмсүгэй.

1/27 дугаар зүйлийн 27.9 дэх хэсэг

“Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан гэрээний дагуу олборлосон газрын тос, уламжлалт бус газрын тос, нүүрсний давхаргын метан хийн бөөний, экспортын болон шууд борлуулалтын үнийг энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан тариф, гэрээний үнийн зохицуулалтад хамруулахгүй.”

2 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 18.2.4 дэх заалт нэмсүгэй:

1/18 дугаар зүйлийн 18.2.4 дэх заалт

“Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан нүүрсний давхаргын метан хийг хайх, үнэлэх, ашиглах, олборлолтын туршилт, туршилтын олборлолт хийх, цуглуулах, ялгах, анхан шатны боловсруулалт хийх, шахах, шингэрүүлэх, хадгах, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагаанд энэ хуулийн 18.2.3-д заасан зохицуулалт хамаарахгүй.”

3 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.3 дахь заалтын “газрын тос” гэсний дараа “, уламжлалт бус газрын тос,” гэж нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.3 дахь заалтын “занар”, “, хийн түлш” гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 19, 23, 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэг:

“19.4.Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан гэрээний гэрээлэгчийг газрын тос, уламжлалт бус газрын тосны барилга, байгууламжийн захиалагч, өмчлөгч, эзэмшигч, хөрөнгө оруулагч гэдэг үндэслэлээр барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй байхыг шаардахгүй.

2/23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсэг:

23.8.Газрын тосны барилга, байгууламжийн зураг төсөлд Монгол Улсын норм, нормативын баримт бичигт тусгайлан зохицуулаагүй асуудлаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт хэрэглэж болно. Тухайн стандарт нь Монгол Улсын заавал мөрдөх техникийн зохицуулалт, хүний эрүүл мэнд, байгаль орчин, галын болон үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны шаардлагаас доогуур байж болохгүй. Гадаад улсын мэргэшсэн инженер, зураг төслийн байгууллагын туршлага, мэргэшлийг эрх бүхий байгууллага тогтоосон шалгуураар дүйцүүлэн хүлээн зөвшөөрч болно.

3/25 дугаар зүйлийн 25.10 дахь хэсэг:

25.10.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан орд ашиглах болон бүтээн байгуулалтын төлөвлөгөөнд туссан байгууламжийн технологи, техникийн шийдэл, аюулгүй ажиллагааны баримт бичгийг энэ хуульд заасан зураг төслийн магадлалд ашиглана. Эрх бүхий байгууллага, магадлалын этгээд өмнө нь эрх бүхий байгууллагаар хянан баталгаажуулсан ижил баримт бичиг, ижил асуудлаар давтан дүгнэлт шаардахгүй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар

хот

**ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь**:

1.Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай:

1/Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан гэрээний ерөнхий загварууд, бүртгэл тооцооны журам, тусгай зөвшөөрлийн төлбөр болон нөөц ашигласны төлбөр төлөх, хуваарилах, зарцуулах журам, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай журмуудыг хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 2 жилийн дотор баталж, мөрдүүлж эхлэх;

2/Газрын тос, уламжлалт бус газрын тосны анхдагч болон боловсруулсан геологийн өгөгдөл, мэдээллийн цахим санг бүрдүүлж, цахим системд бүрэн шилжүүлэх ажлыг 3 жилийн дотор зохион байгуулах;

3/Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг иргэд, олон нийт, орон нутгийн засаг захиргаа, хөрөнгө оруулагчдад сурталчлан таниулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

4/Дагаж гарах захиргааны хэм хэмжээний актуудыг шинэчлэн батлах хүртэлх шилжилтийн хугацаанд урьд нь мөрдөж байсан журмуудын хуульд зөрчигдөхгүй хэсгийг мөрдүүлж, салбарын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА